

Гаалийн ерөнхий газрын даргын 2019 оны
.....06 дугаар сарын05-ны өдрийн
.....А/107 дугаар тушаалын хавсралт

ГААЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ХӨДӨЛМӨРИЙН
АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН НИЙТЛЭГ ЗААВАРЧИЛГАА

Зааварчилгааг мөрдөж эхлэх хугацаа:
2019 оны 06 дугаар сарын 10-ны өдөр

Зааварчилгааг хянасан:
Төрийн захиргааны удирдлагын газрын даргын албан үүргийг түр орлон
гүйцэтгэгч Ц.Гэндэнцэвээн

Зааварчилгааг боловсруулсан:
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл

Улаанбаатар хот
2019 он

ГАРЧИГ

1	ГААЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН НИЙТЛЭГ ЗААВАРЧИЛГАА ГАРГАХ ЭРХ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ	3-4
2	НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР	5-9
3	ГААЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН НИЙТЛЭГ ЗААВАРЧИЛГАА	10-11
4	“ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ, ОРОН ТООГ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ” ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН 2017.11.02-НЫ ӨДРИЙН А/249 ТУШААЛААР БАТЛАГДСАН АЛБАН ТУШААЛЫН АЖЛЫН БАЙРАНД ХАМРАГДАХ ЗААВАРЧИЛГАА	12-13
5	ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ЗААВАРЧИЛГААТАЙ ТАНИЛЦСАН БОЛОН ТАНИЛЦУУЛСАН ТУХАЙ БАТАЛГААЖУУЛАЛТЫН ХУУДАС	14-15
6	ЗААВАРЧИЛГАА №1. ОФФИСИЙН АЛБАН ХААГЧДЫН ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ЗААВАРЧИЛГАА	16-17
7	ЗААВАРЧИЛГАА №2. ГААЛИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХАРИУЦСАН ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ НАРЫН ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ЗААВАРЧИЛГАА	18-27
8	ЗААВАРЧИЛГАА №3. ЛАБОРАТОРИЙН ДАРГА, АХЛАХ ШИНЖЭЭЧ ГААЛИЙН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ, ШИНЖЭЭЧ ГААЛИЙН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ, ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ, НЯРАВ-ЛАБОРАНТЫН ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ЗААВАРЧИЛГАА	28
9	ЗААВАРЧИЛГАА №4. ҮЙЛЧИЛГЭЭ, АЖ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР АЖИЛЛАХ АЛБАН ХААГЧДЫН ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ЗААВАРЧИЛГАА	29-43
10	ЗААВАРЧИЛГАА №5. АЛБАН ТОМИЛОЛТООР ЯВАХ АЛБАН ХААГЧДЫН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА	44-46

---oOo---

ГААЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН НИЙТЛЭГ ЗААВАРЧИЛГАА ГАРГАХ ЭРХ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ

НЭГ. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1. “Монгол улсын үндсэн хууль” /1992 он/
 - 16 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, “Ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, хувийн аж ахуй эрхлэх эрхтэй. Хэнийг ч хууль бусаар албадан хөдөлмөрлүүлж болохгүй;”
2. “Хөдөлмөрийн тухай” хууль /1999 он/
3. “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай” хууль /2008 он/
4. “Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай” хууль /1994 он/
5. Төрийн албаны тухай хууль /2017 он/
 - 55 дугаар зүйлийн 55.3 дахь хэсэг, “Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.”
 - 61 дүгээр зүйлийн 61.1.2 дахь заалт, “Албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай ажиллах нөхцөлөөр хангуулах;”
6. “Гаалийн тухай” хууль /2008 он/
 - 268 дугаар зүйлийн 268¹.1.5 дахь заалт, “Гаалийн байгууллагын үйл ажиллагааг уялдуулан зохицуулж, мэргэжлийн удирдлагаар хангах, үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлэх;”
 - 268 дугаар зүйлийн 268¹.1.6 дахь заалт. “Бараа, тээврийн хэрэгслийг гаалийн хилээр нэвтрүүлэхтэй холбогдсон энэ хуульд заасан дүрэм, журам, зааврыг боловсруулах;”
7. “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай” хууль /2015 он/
8. “Зөрчлийн тухай” хууль /2017 он/
9. “Галын аюулгүй байдлын тухай” хууль /2015 он/

ХОЁР. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1. “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар авах зарим арга хэмжээний тухай” Монгол улсын их хурлын 20 дугаар тогтоол /2013 он/

ГУРАВ. МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай 164 дүгээр зөвлөмж /1981 он, Женев хот/
2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын 155 дугаар конвенц /1981он/

ДӨРӨВ. ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1. “Үндэсний хөтөлбөр батлах тухай” Монгол Улсын Засгийн Газрын 243 дугаар тогтоол /2017 он/
2. “Засгийн Газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай” Монгол улсын Засгийн газрын 121 дүгээр тогтоолын 3.3.19 дэх заалт /2016 он/

3. Засгийн Газрын 2015 оны 269 дүгээр тогтоолоор батлагдсан “Дүрэм шинэчлэн батлах тухай” /Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрэм/
4. Засгийн Газрын 2018 оны 239 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын замын хөдөлгөөний дүрэм”

ТАВ. МОНГОЛ УЛСЫН ХӨДӨЛМӨРИЙН САЙДЫН ТУШААЛ

1. Монгол улсын Хөдөлмөрийн сайдын “Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн зөвлөл байгуулах, орон тооны ажилтан ажиллуулах норматив батлах тухай” А/114 дугаар тушаал/ 2015 он/

ЗУРГАА. ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

1. ГЕГ-ын даргын 2016.12.20-ны өдрийн А/93 дугаар тушаалаар батлагдсан “Гаалийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журам”
2. ГТЕГ-ын даргын А/236 дугаар тушаалаар батлагдсан “Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих нийтлэг журам”
3. “Хөтөлбөр, дүрэм, төлөвлөгөө батлах тухай” ГЕГ-ын даргын 2019 оны А/82 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Гаалийн байгууллагын цацрагийн хамгаалалтын хөтөлбөр”, 2 дугаар хавсралтаар батлагдсан “Гаалийн хяналт, шалгалтад рентген төхөөрөмж ашиглах үед дагаж мөрдөх цацрагийн аюулгүй ажиллагааны дүрэм”, 3 дугаар хавсралтаар батлагдсан “Цацрагийн болзошгүй ослын үед авах арга хэмжээний төлөвлөгөө”
4. ГЕГ-ын даргын 2008 оны 682 дугаар тушаалаар батлагдсан “Гаалийн лабораторийн дүрэм”
5. ГЕГ-ын даргын 2008 оны 683 дугаар тушаалаар батлагдсан “Магадлан шинжилгээ хийх, дүгнэлт гаргах журам”
6. 2014 онд Монгол Улсын сайд, Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газрын дарга, Сангийн сайдын хамтарсан тушаалаар батлагдсан “Улс хоорондын шуудангийн илгээмжийг гаалийн хилээр нэвтрүүлэх журам”
7. ГЕГ-ын даргын 2017 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Ажлын байрны тодорхойлолт”

---oOo---

НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР

1. **“хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй”** гэж хөдөлмөрлөх явцад хүний ажиллах чадвар, эрүүл мэндийг хэвээр хадгалах, эрүүл, аюулгүй нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн нийгэм, эдийн засаг, зохион байгуулалт, техник, технологи, ариун цэвэр, эрүүл ахуйн арга хэмжээ авах, эмчлэх, сувилах, нөхөн сэргээх, эрсдэлээс хамгаалах үйл ажиллагааг;
2. **“хөдөлмөрийн аюулгүй байдал”** гэж хөдөлмөрлөх явцад хүний эрүүл мэнд, хөдөлмөрлөх чадварт үйлдвэрлэлийн аюултай, хортой хүчин зүйлийн нөлөөллийн түвшин нь эрүүл ахуйн зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтрээгүй байхыг;
3. **“хөдөлмөрийн эрүүл ахуй”** гэж хөдөлмөрлөх явцад хими, физик, биологийн хүчин зүйлээс шалтгаалан хүний бие махбодь, мэдрэл сэтгэхүйд өөрчлөлт орж өвчлөх, хөдөлмөрийн чадвараа түр болон бүрэн алдахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үйл ажиллагааг;
4. **“хөдөлмөрийн нөхцөл”** гэж хөдөлмөрлөх явцад хүний ажиллах чадвар, эрүүл мэндэд дагнасан буюу хамссан байдлаар нөлөөлөх ажлын байрны болон үйлдвэрлэлийн орчныг;
5. **“үйлдвэрлэлийн хортой хүчин зүйл”** гэж хүний эрүүл мэндэд нөлөөлж өвчлүүлэх, сэтгэхүйд өөрчлөлт оруулах, хөдөлмөрлөх чадварыг бууруулах, мэргэжлийн өвчин бий болгох уршиг бүхий үйлдвэрлэлийн хүчин зүйлийг;
6. **“үйлдвэрлэлийн аюултай хүчин зүйл”** гэж ажлын ээлжийн хугацаанд хурц хордлого, үйлдвэрлэлийн осолд хүргэх, хүний эрүүл мэнд, амь насанд аюул учруулах хүчин зүйлийг;
7. **“ажлын байран дахь эрсдэл”** гэж иргэнийг үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалах өвчинд хүргэж болзошгүй ажлын байрны нөхцөлийг;
8. **“эрсдэлийн үнэлгээ”** гэж ажлын байрны эрсдэлд үнэлэлт өгөх үйл явцыг;
9. **“ажлын байр”** гэж иргэн, ажилтны гүйцэтгэх ажил үүрэгтэйгээ холбоотойгоор хүрэлцэн очих ёстой ажил олгогчийн шууд ба шууд бус хяналтын дор байх бүх байрыг;
10. **“хурц хордлого”** гэж цацраг болон биологийн идэвхт бодис, химийн хорт бодисын нөлөөгөөр хурц, цочмог хэлбэрээр богино хугацаанд хордохыг;
11. **“тусгай хувцас”** гэж үйлдвэрлэлийн хортой, аюултай хүчин зүйлийн нөлөөллөөс хамгаалах зориулалт бүхий хувцас, гутал, малгай, бээлий зэрэг хэрэгслийг;

12. **“нэг бүрийн хамгаалах хэрэгсэл”** гэж үйлдвэрлэлийн хортой, аюултай хүчин зүйлийн нөлөөллөөс ажилтныг хамгаалах зориулалт бүхий хэрэгслийг;

13. **“хамтын хамгаалах хэрэгсэл”** гэж үйлдвэрлэлийн хортой, аюултай хүчин зүйлийн нөлөөллөөс хоёр ба түүнээс дээш тооны ажилтныг нэгэн зэрэг хамгаалах зориулалт бүхий хэрэгслийг;

14. **“хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцоо”** гэж хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаархи бодлого, зорилтыг тодорхойлох, тэдгээрийн хэрэгжилтийг зохион байгуулах, манлайлах, хяналт тавих, үнэлгээ хийх харилцан холбоо бүхий удирдлагын үйл ажиллагааны цогцыг;

15. **“ахуйн байр”** гэж иргэн, ажилтны хөдөлмөрлөх хэвийн үйл ажиллагааг хангахад чиглэсэн, тусгайлан төхөөрөмжилсөн хувцас солих, түр амрах, хооллох, бие засах, усанд орох, дулаацах зэрэг зориулалтын өрөө, тасалгааг;

16. **“үйлдвэрлэлийн ажлын байрыг хөдөлмөрийн нөхцөлөөр аттестатчилах”** гэж гүйцэтгэж буй ажлын аюултай, хортой, хүнд, ачаалалтай байдал нь хөдөлмөрийн эрүүл ахуйн нөхцөлийн хэм хэмжээнд нийцэж байгаад үнэлгээ өгөхийг;

17. **“хөдөлмөрийн аюулгүй нөхцөл”** гэж ажилтанд нөлөөлөх үйлдвэрлэлийн хортой ба аюултай хүчин зүйлийн нөлөөллийн түвшин нь хөдөлмөрийн аюулгүй байдлын тогтоосон хэм хэмжээнээс хэтрээгүй байхыг;

18. **“үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн аюулгүй байдал”** гэж зураг төсөл, техникийн баримт бичигт заасан нөхцөлийн дагуу тоног төхөөрөмжийг ажиллуулахад хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны шаардлага хангасан байхыг;

19. **“хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандарт”** гэж хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар эрх бүхий байгууллагаас тогтоосон хэм хэмжээг;

20. **“үйлдвэрлэлийн осол”** гэж хөдөлмөр эрхлэгч иргэн хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх явцад үйлдвэрлэлийн болон түүнтэй адилтгах хүчин зүйлийн үйлчлэлд өртөхийг;

21. **“үйлдвэрлэлийн орчин”** гэж аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны талбай, гадна орчныг;

22. **“эрсдэлийн түвшин их ажлын байр”** гэж хөдөлмөрлөх явцад ажилтанд учирч болзошгүй аюултай хүчин зүйлийн магадлал нь зөвшөөрөгдөх хэмжээнээс өндөр байх;

23. **“ажил олгогч”** гэж хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр ажилтан авч ажиллуулж байгаа этгээдийг;

24. **“ажилтан”** гэж ажил олгогчтой хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж байгаа иргэнийг;

25. **“хөдөлмөрийн гэрээ”** гэж нэг талаас ажилтан нь ажил олгогчоос хуульд нийцүүлэн тогтоосон хөдөлмөрийн дотоод журмын дагуу тодорхой ажил гүйцэтгэх, нөгөө талаас ажил олгогч нь ажилтанд хөдөлмөрийн үр дүнд тохирсон цалин хөлс олгох, хууль тогтоомж болон хамтын гэрээ, хэлэлцээрт заасан хөдөлмөрийн нөхцөлөөр хангах тухай харилцан үүрэг хүлээсэн тохиролцоог;

26. **“хөдөлмөрийн хамтын маргаан”** гэж хамтын гэрээ, хэлэлцээр байгуулах, биелүүлэх, биелэлтэд нь хяналт тавих явцад гэрээ, хэлэлцээрт оролцогч талуудын хооронд үүссэн саналын зөрүүг;

27. **“хөдөлмөрийн нөхцөл”** гэж хөдөлмөрлөх явцад ажилтны ажиллах чадвар, эрүүл мэндэд дагнасан буюу хамссан байдлаар нөлөөлөх ажлын байрны болон үйлдвэрлэлийн орчны хүчин зүйлийг;

28. **“байнгын ажлын байр”** гэж ажил олгогчийн заасан ажлын байранд, тогтоосон горимын дагуу түүнээс олгосон хөдөлмөрийн багаж хэрэгслээр, ажил олгогч, эсхүл түүний төлөөлөгчийн удирдлагын дор баталсан норм, үнэлгээ, сүлжээгээр цалин хөлс авч, ажлын өдөр, ээлжийн давтамжтайгаар гүйцэтгэх ажил, үүргийг

29. **“тээврийн хэрэгсэл”** гэж хүн, ачаа, суурилагдсан тоног төхөөрөмжийг замаар тээвэрлэхэд зориулсан хэрэгслийг;

30. **“механикжсан тээврийн хэрэгсэл”** гэж мопедоос бусад, хөдөлгүүрээр тоноглогдсон тээврийн хэрэгслийг;

31. **“жолооч”** гэж тээврийн хэрэгсэл жолоодож яваа хүн, жолоодлогын дадлага хийлгэж яваа багш, замаар ердийн хөсөг унаж, хөтөлж яваа хүнийг;

32. **“зам”** гэж тээврийн хэрэгслээр зорчиход зориулсан зурвас газрыг. Зорчих хэсэг болон түүний хажуугийн хөвөө, явган хүний зам, тусгаарлах зурвас замд хамаарна;

33. **“замын хөдөлгөөн”** гэж нийтийн хэрэгцээний зам дээр явганаар болон тээврийн хэрэгслээр хүн, ачаа шилжих үйл ажиллагааг;

34. **“зам тээврийн осол”** гэж зам дээр тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс үүдэн хүний амь нас, эрүүл мэнд хохирох, тээврийн хэрэгсэл болон зам, замын байгууламж эвдэрч гэмтэх, ачаа болон бусад эд хөрөнгийн хохирол учрахыг;

35. **“замын хөдөлгөөнд оролцогч”** гэж замаар явж байгаа жолооч, тээврийн хэрэгслээр зорчигч, явган зорчигчийг;

36. **“замын хөдөлгөөний аюулгүй байдал”** гэж замын хөдөлгөөнд оролцогчийг зам тээврийн осол, түүнээс үүдэн гарах хор уршгаас хамгаалсан байдлыг;

37. **“замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах”** гэж зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх, ослоос үүдэн гарах хохирлыг багасгахад чиглэсэн үйл ажиллагааг;

38. **“явган зорчигч”** гэж замаар явган яваа /зам дээр ажил үүрэг гүйцэтгэж яваагаас бусад/ хүн, жагсаалаар яваа болон хөгжлийн бэрхшээлтэй хүний тэргэнцэртэй, түүнчлэн тэрэг түрж, чарга чирж, мотоцикл, мопед, унадаг дугуйг хөтөлж замаар яваа хүнийг;

39. **“гал түймэр”** гэж гал хараа хяналтаас гарч, хүний амь нас, эрүүл мэнд, хувь хүн, хуулийн этгээдийн эд хөрөнгө, байгаль орчин, нийгэмд хохирол учруулахыг;

40. **“гал түймэр унтраах”** гэж гал түймрийн үед хүний амь насыг аврах, гал түймрийг унтраахын тулд тодорхой хүн хүч, техник хэрэгслээр тохирсон арга, хэлбэрийг ашиглан гүйцэтгэх үйл ажиллагааг;

41. **“галын аюулгүй байдал”** гэж учирч болзошгүй гал түймрийн аюулаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, байгаль орчин болон нийтийн ашиг сонирхлыг хамгаалсан байдлыг;

42. **“гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмж”** гэж барилга байгууламж дахь гал түймрийг илрүүлэх, мэдээлэх, унтраах автомат тоног төхөөрөмж, утаа зайлуулах систем, гал унтраах усан хангамж, хүн нэг бүрийн болон нийтийн тусгай аврах хэрэгслийг;

43. **“галын аюулгүй байдлын норм, нормативын баримт бичиг”** гэж галын аюулгүй байдлыг хангахтай холбоотой дүрэм, журам, заавар, норм, стандартыг;

44. **“гал түймрийн аюултай нөхцөл байдал”** гэж гал түймэр гарсан тохиолдолд хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд шууд аюул учруулах нөхцөл бүрдсэнийг;

45. **“гал түймэр гарсан тухай акт”** гэж гал түймрийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учирсан болохыг нотолсон баримт бичгийг;

46. **“гал түймэр гарсан тухай тэмдэглэл”** гэж гал түймрийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учраагүй болохыг тодорхойлсон баримт бичгийг;

47. **“гал түймрийн аюулын үнэлгээ”** гэж барилга байгууламжийн ангилал, зураг төсөл, хийц, бүтээц, үйлдвэрлэлийн технологи, гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмжийн зориулалт, ашиглалт нь норм, нормативын шаардлагад нийцэж байгаа эсэх, гал түймрээс учирч болзошгүй хохирлын хэмжээг тодорхойлж үнэлэхийг;

48. **“гал түймрээс хамгаалах үйлчилгээ”** гэж гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах, гал түймрээс хамгаалах нэмэлт арга хэмжээ авах, гал түймэртэй тэмцэх хэсэг, гал түймэртэй тэмцэх гэрээт анги, хяналтын нэгж ажиллуулахыг;

49. **“галын аюултай бүтээгдэхүүн”** гэж галын эх үүсвэрээс болон химийн урвалын үйлчлэлээр хялбар авалцан асах, хорт хий, утаа ялгаруулах, тэсэрч дэлбэрэх аюултай бодис, материалыг ойлгоно.

---oOo---

ГААЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН НИЙТЛЭГ ЗААВАРЧИЛГАА

Гаалийн байгууллагын нийт ажилтан, албан хаагчид албан үүргээ гүйцэтгэхдээ ажиллах чадвар, эрүүл мэндийг хэвээр хадгалах, эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн хөдөлмөр хамгааллын эрхийг хэрэгжүүлэх баталгааг бий болгохтой холбоотой харилцааг зохицуулахад энэхүү зааварчилгааны зорилго оршино.

Гаалийн байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгаа /цаашид ХАБЭАЗ гэх/ нь дараах хэлбэртэй байна. Үүнд:

1. Урьдчилсан зааварчилгаа,
2. Ажлын байран дахь анхан шатны зааварчилгаа,
3. Давтан зааварчилгаа.

Урьдчилсан зааварчилгаа гэдэг нь Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомж, эрүүл ахуй хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа, аюулгүй ажиллагааны улсын стандарт, гаалийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, гаалийн байгууллагын үйл ажиллагааны онцлог, техникийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, ариун цэвэр, галын аюулгүй байдал, хувийн хамгаалах хэрэгсэл, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, хурц хордлого, үүсэх шалтгаан, осолдогчдод үзүүлэх анхан шатны тусламж зэрэг асуудлыг хамарна. Урьдчилсан зааварчилгааг эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны асуудал хариуцсан ажилтан, зөвлөлөөс өгнө.

Ажлын байран дахь анхан шатны зааварчилгаа-г ажилтны ажилладаг гаалийн газар, хороо, салбар, нэгжийн ажилтны ажлын байр өөрчлөгдөх үед мөн ажилд шинээр орсон болон үйлдвэрлэлийн дадлага хийхээр ирж урьдчилсан зааварчилгаа авсан хүмүүс, оюутан сурагчдад өгнө.

Ажлын байран дахь анхан шатны зааварчилгаанд тухайн ажилтны ажлын байр, гүйцэтгэх ажлын онцлог, машин техник, багаж, хэрэгсэл, ашиглах болон ажлын явцад үүсч болох сөрөг хүчин зүйл, түүнээс хамгаалах хэрэгсэл, тэдгээрийг ашиглах заавар, аюулгүйн ажиллагааны арга барил, гаалийн хяналт шалгалтын болон лабораторийн тоног төхөөрөмж, тээвэрлэх машин механизм, даралтад сав, шугам хоолой, цахилгаан тоног төхөөрөмжийн ашиглалт, аюулгүй ажиллагааны шаардлага, галын аюулгүй байдлыг хангах журам, гал түймэр гарсан үед авах арга хэмжээ, гал унтраах хэрэгсэл, тэдгээрийг ашиглах, хадгалах, осолдогчдод анхан шатны тусламж зэрэг болно. Энэ зааварчилгааг тухайн газар, хороо, салбар, нэгжийн дарга, эрхлэгч нар тухай бүр өгнө.

Давтан зааварчилгаа-г ажилтанд өмнө олгосон мэдлэгийг бататгах, баяжуулах зорилгоор ажлын байран дахь анхан шатны зааварчилгааны агуулгаар өгнө.

Давтан зааварчилгаа нь 3 хэлбэртэй байна. Үүнд:

- а. ээлжит давтан,
- б. ээлжит бус давтан,
- с. ажлын байран дахь өдөр тутмын.

Ээлжит давтан зааварчилгаа-г шинэ техник технологи, машин механизм, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл нэвтрүүлсэн болон ХАБЭА-н дүрэм, журам өөрчлөгдсөн тохиолдолд өгнө.

ХАБЭАЗ-г ноцтой зөрчсөн хүмүүст, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас болон түр хугацаагаар ажлаас хөндийрөөд эргэн ажилдаа орсон ажилтанд, мөн албан томилолтоор ажиллахаар явах хүмүүст **ээлжит бус давтан зааварчилгаа**-г өгнө.

Түүнчлэн ээлжийн ажилтай албан хаагчид ээлж хооронд зорчиход, албан томилолтоор ажиллахаар явах үед тээврийн хэрэгслийн болон хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны талаар холбогдох албан тушаалтан зааварчилгаа өгч, баримтаар баталгаажуулсан байна.

Ажлын байран дахь өдөр тутмын зааварчилгаа-г гаалийн лаборатори, вагон, цистерн, том оврын тээврийн хэрэгсэл бүхий ачаа тээш, амьтан, тэсэрч дэлбэрэх бодис, химийн хортой, аюултай бодис зэрэг аюултай ачаанд гаалийн хяналт шалгалтыг хийж байгаа хүмүүст өгнө.

Ажлын байран дахь өдөр тутмын зааварчилгаа нь товч тодорхой байх ба ажил эхлэхийн өмнө өгнө.

Ээлжийн амралттай, эрүүл мэндийн болон бусад шалтгаанаар чөлөөтэй, албан томилолттой, сургалтад хамрагдсан, удирдлагын шийдвэрээр өөр ажил үүрэг гүйцэтгэж байгаа, жирэмсний болон амаржсаны амралттай, хүүхэд асрах чөлөөтэй байгаа албан хаагчдыг түр орлон гүйцэтгэх тохиолдолд тухайн ажлын байранд мөрдөгдөх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгааг дагаж ажиллана.

Харьяа гаалийн газар, хороод энэхүү зааварчилгааг үндэслэж, үйл ажиллагааныхаа онцлогт тохируулан “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгаа”-г батлан мөрдүүлж болно.

---oOo---

**“ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ, ОРОН ТООГ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ”
ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН 2017.11.02-НЫ ӨДРИЙН А/249
ТУШААЛААР БАТЛАГДСАН АЛБАН ТУШААЛЫН АЖЛЫН БАЙРАНД
ХАМРАГДАХ ЗААВАРЧИЛГАА**

Зохион байгуулалтын бүтэц	Албан тушаал	Ажлын байр	Тайлбар	Зааварчилгаа №
ГЕГ-ын зохион байгуулалтын нэгж болон дэргэдэх байгууллага	-Дарга, -Дэд дарга, -Газар, хэлтсийн дарга, орлогч дарга, -Төвийн дарга, -Лабораторийн дарга, -Албаны дарга, -ГУАБ, ГУБ, -Бичиг хэргийн эрхлэгч, -Бичээч, бичиг хэргийн ажилтан, -Хүргэлт, лавлагаа гаргах ажилтан, -Даргын туслах, -Нярав, номын санч-нярав, -Бага эмч, -Спорт заалны менежер, -Архивын эрхлэгч, -Архивын ажилтан	Оффисийн байранд		
Харьяа гаалийн газар, хороод	-Дарга, -Орлогч дарга, -Албаны дарга, -Хүний нөөц, сургалт хариуцсан ГУАБ, ГУБ -Захиргаа, дотоод асуудал хариуцсан ГУАБ, -Дотоод ажил, тайлан, төлөвлөгөө хариуцсан ГУАБ, -Тайлан, төлөвлөгөө хариуцсан ГУБ, -Хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан ГУБ, -Бичиг хэргийн эрхлэгч	Оффисийн байранд	Захиргааны чиглэлээр:	1
	-Эрсдэлийн удирдлага хариуцсан ГУАБ, ГУБ, -Мэдээллийн технологи хариуцсан ГУАБ, ГУБ, -Статистик хариуцсан ГУБ		Эрсдэлийн удирдлага, статистик, мэдээллийн технологийн чиглэлээр:	
	-Хэрэг бүртгэгч ГУАБ, -Гаалийн зөрчил, хэрэг бүртгэгч ГУБ		Гаалийн зөрчилтэй тэмцэх, хэрэг бүртгэх чиглэлээр:	
	-Бичиг баримтын бүрдүүлэлт хариуцсан ГУАБ, ГУБ -Барааны ангилал, үнэлгээний хяналт хариуцсан ГУБ, -Татвар, тарифын асуудал хариуцсан ГУБ		Гаалийн үнэ, үнэлгээ, бүрдүүлэлтийн чиглэлээр:	
	-Нягтлан бодогч ГУАБ, ГУБ, -Аж ахуй хариуцсан ГУАБ, -УОБ, тооцоот хуудас хариуцсан нярав ГУБ, -Аж ахуйн үйл ажиллагаа хариуцсан зохион байгуулагч, -Цогцолборын менежер, -Үнэт цаас, мөнгөн касс, аж ахуй хариуцсан нярав		Санхүүгийн чиглэлээр:	
Харьяа гаалийн газар, хороод	-Салбарын эрхлэгч, -ГХШ хариуцсан ГУАБ, ГУБ, -Чөлөөт бүс хариуцсан ГУАБ, ГУБ, -Эрэлч нохой хариуцсан ГУБ, -Рентген тоног төхөөрөмж хариуцсан ГУБ	Гаалийн хяналтын бүсэд	Гаалийн хяналт, шалгалтын чиглэлээр:	2

Гаалийн төв лаборатори болон харьяа гаалийн газар, хороодын салбар лаборатори	-Лабораторийн дарга, -Ахлах шинжээч ГУАБ, -Шинжээч ГУАБ,ГУБ, -Нярав, лаборант	Лабораторид	Лабораторийн чиглэлээр:	1 ба 3
Үйлчилгээ, аж ахуйн алба болон харьяа гаалийн газар, хороод	-Цогцолборын менежер, -Аж ахуйн үйл ажиллагаа хариуцсан зохион байгуулагч, -Спорт заалны менежер, -Нярав, номын санч-нярав, үнэт цаас, мөнгөн касс, аж ахуй хариуцсан нярав, УОБ, тооцоот хуудас хариуцсан нярав -Бага эмч, -Цахилгааны инженер, -Цахилгаанчин, дизельчин, -Лифтчин, -Сантехникийн инженер, -Сантехникийн слесарь, -Хэвлэх цехийн инженер, -Хэвлэх цехийн ажилтан, -Архивын эрхлэгч, -Архивын ажилтан, -Жолооч, -Малын эмч, -Нохой маллагч, -Сахиул, манаач, -Үйлчлэгч, -Мужаан, -Гагнуурчин, -Галч, -Сахиул, худгийн ажилтан, -Худгийн моторчин,	Оффисийн болон ажлын байранд	Үйлчилгээ, аж ахуйн чиглэлээр:	1 ба 4
ГЕГ-ын зохион байгуулалтын нэгж, дэргэдэх байгууллага болон харьяа гаалийн газар, хороод	Албан томилолтоор явах албан хаагчид	ГЕГ, харьяа гаалийн газар, хороодод болон хөдөө, орон нутагт	Албан ажлаар:	5

---oOo---

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ЗААВАРЧИЛГААТАЙ ТАНИЛЦСАН БОЛОН ТАНИЛЦУУЛСАН ТУХАЙ БАТАЛГААЖУУЛАЛТЫН ХУУДАС

“Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгаатай танилцсан болон танилцуулсан тухай баталгаажуулалтын хуудас”-ыг дараах зааварчилгаанд тухай бүр өгч, гарын үсгээр баталгаажуулна. Үүнд:

- Ажлын байран дахь анхан шатны зааварчилгаа,
- Ээлжит давтан зааварчилгаа,
- Ээлжит бус давтан зааварчилгаа (Албан томилолтоор явахаас бусад тохиолдолд),
- Ажлын байран дахь өдөр тутмын зааварчилгаа.

ГЕГ-ын зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллага болон харьяа гаалийн газар, хороод нь “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгаатай танилцсан болон танилцуулсан тухай баталгаажуулалтын хуудас” бүхий Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгааны дэвтэртэй болсон байна.

Дээрх дэвтрийг дууссан тухай бүр байгууллагын архивт (3 жил) хадгална.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгааны дэвтрийн
баталгаажуулалтын хуудасны загвар

**ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ЗААВАРЧИЛГААТАЙ
ТАНИЛЦСАН БОЛОН ТАНИЛЦУУЛСАН ТУХАЙ БАТАЛГААЖУУЛАЛТ**

Нэгжийн нэр

№	Овог, нэр	Албан тушаал	Зааварчилгаатай танилцсан огноо	Гарын үсэг

Танилцуулсан ажилтны овог нэр, албан тушаал, гарын үсэг

.....

---oOo---

ЗААВАРЧИЛГАА №1

НЭГ. ОФФИСИЙН АЛБАН ХААГЧДЫН ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ЗААВАРЧИЛГАА

1.1.1 Ажлын төв байр (оффис)-нд ажил үүргээ гүйцэтгэж байгаа нийт албан хаагчид дараах зааварчилгааг мөрдөж ажиллана. Үүнд:

- Захиргаа, санхүү, бичиг баримтын бүрдүүлэлт, эрсдэлийн удирдлага, зөрчил хариуцсан албан хаагчид ХАБЭАЗ-тай танилцан, өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөж ажиллана.
- Өглөө ажлын байранд ирээд цахилгаан хэрэгслүүдийг (компьютер, хэвлэгч, хувилагч, агааржуулагч гэх мэт) асааж, бүрэн бүтэн, хэвийн ажиллаж байгаа эсэхийг шалгана.
- Өрөө тасалгаандаа цонх, хаалгыг нээж, агааржуулалт хийнэ.
- Ажлын байранд согтууруулах ундаа, тамхи хэрэглэхийг хориглоно.
- Өрөө, тасалгаанд галын аюулгүй байдлыг хангаж, эвдрэл, гэмтэлтэй цахилгаан хэрэгсэл ашиглахгүй байх, үдийн цайны завсарлага болон ажил тарсаны дараа бүх цахилгаан хэрэгслийг залгуураас салган, галын аюулгүй байдлыг хангана.
- Тоног төхөөрөмж, компьютер, техник хэрэгсэл нь цахилгаан гүйдэлд залгах, асаах товчлуурыг дарах үед хэвийн асахгүй, ажиллахгүй байх, цахилгаан тоног төхөөрөмж болон цахилгааны залгуурт халалт үүсэх зэрэг тохиолдолд дур мэдэн асааж, ажиллуулах оролдлого хийлгүйгээр холбогдох мэргэжилтэнд хандаж, засварлуулна.
- Компьютерын нэр, сүлжээний тохиргоог солихгүй байх. Шаардлага гарсан тохиолдолд хариуцсан мэргэжилтэнд мэдэгдэн зохих үйлчилгээг хийлгэнэ.
- Ажлын өрөө болон хонгилд ил болон далд угсрагдсан сүлжээний утсууд гэмтсэн, орооцолдсон, далд монтажаас утас ил гарсан тохиолдолд байгууллагын холбогдох нэгж, мэргэжилтэнд мэдэгдэнэ.
- Мэдээллийн аюулгүй байдлыг хангах талаар хариуцсан мэргэжилтний өгсөн шаардлагыг биелүүлнэ.
- Хариуцаж буй компьютер, техник хэрэгсэлд засвар, үйлчилгээг зөвшөөрөлгүй гадны хүнээр хийлгэхийг хориглоно.
- Ажлын өрөө солих, байрлалаа шилжүүлэх тохиолдолд дур мэдэн сүлжээний утсаа солих, өөрийн компьютерт тохируулсан сүлжээний тохиргоог дур мэдэн өөрчлөхийг хориглоно.
- Орой ажил тарахад хамгийн сүүлд гарсан ажилтан ажлын байрны цонхыг хааж, цахилгаан хэрэгслүүдийг залгуураас салгаж, унтраасан эсэхийг шалгаж, өрөөг түгжин лацдаж, харуул (жижүүр)-д түлхүүрийг хүлээлгэж өгнө.

1.1.2 Мэдээллийн технологи хариуцсан албан хаагчид ажил үүргээ гүйцэтгэхдээ:

- Серверийн өрөөний хөргөлтийн төхөөрөмжийн хөргөлтийн шингэн агуулах савны битүүмжлэл алдагдахаас сэргийлнэ.
- Серверийн өрөөний цахилгааны эх үүсвэрийн хэвийн найдвартай ажиллагааг хангаж ажиллана.
- Нөөц дизель станцын шатах, тослох материалтай харьцахдаа галын аюулгүй байдлыг хангана.

- Цахилгааны утас, сүлжээний утсыг бусдын хөлд саад болохооргүйгээр эмх цэгцтэй болгон далдалж, ажилчдыг гэмтэх, бэртэхээс сэргийлнэ.
- Тог тасарсан үед тог баригчийн ажиллагааг шалгаж, дизель станцыг хэвийн ажиллагааны горимд шилжүүлнэ.
- Тог тасарсан үед сэлгэн залгагчтай ажиллахдаа тогонд цохиулахаас сэргийлж, хянах самбар дээрх тогны гүйдлийн мэдээллийг шалгаж, асуудал гарсан тохиолдолд байгууллагын мэргэжлийн цахилгаанчинд хандана.

---oOo---

ЗААВАРЧИЛГАА №2

НЭГ. ГААЛИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХАРИУЦСАН ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ НАРЫН ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ЗААВАРЧИЛГАА

2.1 Гаалийн хяналтын бүсэд хяналт шалгалт хариуцан ажиллаж байгаа албан хаагчид ГТЕГ-ын даргын А/236 дугаар тушаалаар батлагдсан “Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих нийтлэг журам”-ыг баримтлан дараах зааварчилгааг мөрдөж ажиллана.

2.1.1 Хүний биед гаалийн хяналт, шалгалтын зорилгоор үзлэг хийхдээ:

- Гаалийн зөрчил илэрсэн, эсхүл барааг биедээ нуусан гэх хангалттай үндэслэл, сэжиг байгаа бол ГТХ-ын 247 дугаар зүйлийг баримтлан хүний биед үзлэг хийнэ.
- Хүний биед үзлэг хийхэд шаардагдах хуульд заасан нөхцөлийг бүрдүүлж ажиллана.
- Хүний биед рентгэн төхөөрөмжөөр үзлэг хийхэд “Хөтөлбөр, дүрэм, төлөвлөгөө батлах тухай” ГЕГ-ын даргын 2019 оны А/82 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Гаалийн хяналт шалгалтад рентген төхөөрөмж ашиглах үед дагаж мөрдөх цацрагийн аюулгүй ажиллагааны дүрэм”-ийг дагаж мөрдөнө.
- Хүний бие, эрхтэнд үзлэг хийхдээ халдвар хамгааллын дэглэмийн үүднээс 1 удаагийн амны хаалт зүүж, бээлий өмсөж ажиллана.
- Шаардлагатай тохиолдолд нэмэлт гэрэлтүүлэг ашиглан, үзлэгийг эмчээр хийлгэж, эрүүл ахуйн шаардлага хангасан 1 удаагийн багаж, хэрэгсэл ашиглана.
- Эрүүл ахуйн шаардлага хангасан 1 удаагийн багаж, хэрэгсэл ашиглах тухай холбогдох этгээдэд мэдэгдэж, багаж хэрэгслийг түүний дэргэд задалж ашиглана.
- Үзлэг дууссаны дараа гараа угааж, ариутгана.
- Хэрэглэсэн багаж, хэрэгслийг холбогдох журмын дагуу устгана.
- Үзлэг хийсэн тухай тэмдэглэл хөтөлнө.

2.1.2 Бараанд гаалийн хяналт шалгалт хийхдээ:

- Бараанд хяналт, шалгалт хийхдээ ГТХ-ийн 240-р зүйлд заасан “Гаалийн хяналтын хэлбэр”-ээр ГТХ-ийн 244, 245, 246, 248 дугаар заалтын дагуу шалгах, шалгахдаа ХАБЭАЗ-г мөрдөж ажиллана.
- Гаалийн хяналт, шалгалтыг хийхдээ дүрэмт хувцас, ажлын хувцас, хамгаалалтын хэрэгслийг хэрэглэж, ажилд гарах бэлтгэлийг хангасан байна.
- Мэдүүлсэн бараа нь хууль бусаар нэвтрүүлэхээр завдсан, нийтийн аюулгүй байдал, хүн ам, ургамал, амьтан, хүрээлэн буй орчинд аюул учруулж болохуйц тэсэрч дэлбэрэх бодис, түргэн шатах бараа, цацраг идэвхт бодис, химийн хорт болон аюултай бодис, мансууруулах, сэтгэцэт нөлөөт эм, түүх, соёлын үнэт зүйлс байгаа тохиолдолд тухайн бараанд гаалийн хяналт шалгалт хийхдээ энэхүү заавраас гадна ажлын байран дахь өдөр тутмын зааварчилгааг мөрдөж, анхаарал болгоомжтой ажиллана.
- Барааг рентген төхөөрөмжөөр шалгах тохиолдолд ГЕГ-ын даргын 2019 оны А/82 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Гаалийн хяналт шалгалтад

рентген төхөөрөмж ашиглах үед дагаж мөрдөх цацрагийн аюулгүй ажиллагааны дүрэм"-ийг мөрдөнө.

- Бараанд биет үзлэг хийх тохиолдолд барааны сонгосон горим, нэр төрөл, онцлог байдал, сав, баглаа, боодол эрсдэл тооцсон зэргээс хамаарч хяналт шалгалтыг хэрхэн хийх арга замыг тодорхойлно.
- Бараа нь химийн хорт болон аюултай бодис байгаа тохиолдолд "Чанарын гарын авлага"-д заагдсан "Аюулгүй ажиллагааны дүрэм"-ийг дагаж мөрдөнө.
- Барааг задлуулж шалгахдаа гэмтэх, бэртэхээс болгоомжлоно.
- Хайрцаг, баглаа боодолд хадаас, төмөр утас, бүслүүр, төмрийн үзүүр байгаа эсэхийг анхаарна.
- Дээр нь гишгэж буй ачаа даахгүй нурах, цөмрөхөөс болгоомжлох, ачааны тогтвортой эсэхийг урьдчилан шалгана.
- Барааг шилжүүлэх, зөөхдөө алдаж, асгах, унагахаас болгоомжлох, хөл, гараа гэмтээхээс урьдчилан сэргийлнэ.
- Түргэн муудах, хагарч гэмтэх, ачилт, тээвэрлэлт, хадгалалт хамгаалалтын онцгой нөхцөл шаардсан (ГТХ-ийн 29 дүгээр зүйл) барааг шалгахдаа тухайн барааны онцлогийг харгалзан үзэж, шалгалтыг аюулгүй хийх арга замаа урьдчилан тооцож, тодорхойлох, түүний дагуу шалгалтыг хийнэ.
- Мал, амьтны гаралтай түүхий эдийг ачиж, буулгахын өмнө холбогдох мэргэжлийн байгууллагаар халдварын шалгалт хийлгэнэ.
- Барааг хууль бусаар нэвтрүүлэхдээ барааг нуувч болгон ашигласан тохиолдолд уг барааг задлуулахдаа болгоомжтой хандах, гарч болох эрсдэлээс өөрийгөө хамгаалж ажиллана.
- Барааг задлахаар ашиглаж буй багаж, хэрэгсэлтэй болгоомжтой хандах. Шаардлагатай тохиолдолд малгай, бээлий, амны хаалт, нүдний шилийг зориулалтын дагуу ашиглана.
- Шаардлагатай тохиолдолд зохих мэргэжлийн байгууллагыг шалгалтанд оролцуулна.
- Чингэлэгт гаалийн хяналт шалгалт хийхдээ өргөсөн чингэлэгийн доор зогсохыг хориглоно.
- Чингэлгийг нээх үедээ чингэлгээс эд зүйл унаж, бэртэхээс болгоомжлон, аюулгүй зайд байрласан байна.
- Хайрцаг, савтай ачаанд шалгалт хийхдээ газар бүрэн буулгаж, байрлуулсан байна.
- Гэрэлтүүлэггүй талбайд шөнө ачаа шалгахыг хориглоно

2.1.3 Төмөр замын тээврийн хэрэгсэл, түүгээр тээвэрлэгдэж буй бараанд гаалийн хяналт шалгалт хийхдээ:

- Төмөр замын тээврийн хэрэгсэл, түүнд ачсан барааг шалгахад "Төмөр замын тээврийн хэрэгсэл, түүгээр тээвэрлэгдэж буй барааг шалгахад тавигдах аюулгүй ажиллагааны зааварчилгаа"-г дагаж мөрдөнө.
- Төмөр замын дагуу зөвхөн замын хажуугаар явах ба хөдөлж байгаа галт тэрэг, хөдөлгүүр, тээврийн хэрэгслээс илүү гарсан зүйл байгаа эсэхийг сайн шалгана.
- Галт тэрэгний цаанаас гарч ирэхдээ уг зам дээр өөр хөдөлгөөнтэй галт тэрэг, цуваа байгаа эсэхийг шалгаж, төмөр замыг тэгш өнцгөөр хөндлөн гарна.
- Галт тэргийг 3 метрээс багагүй зайд тойрч гарна.

- Галт тэрэг, зүтгүүрт шалгалт хийхдээ цахилгааны аюулгүй байдлыг сахиж ажиллах ба цахилгааны механик, галт тэрэгний үйлчлэгч, цахилгаанчин нарын аль нэгийг байлцуулан, цахилгааныг салгасан, эсхүл аюулгүй гэсний дараа шалгалт, үзлэгийг хийнэ.
- Ачааны галт тэрэгний хаалгыг төмөр замын болон бусад холбогдох ажилтнуудаар онгойлгуулах ба энэ үед аюулгүй байдлаа хангаж, хол зайд байна.
- Төмөр замын тэмдэг, тэмдэглэгээ, гэрэл дохионы утга, агуулыг мэддэг байх шаардлагатай.
- Галт тэрэг бүрэн зогсоогүй байхад бууж, суухыг хориглоно.
- Хөдөлж байгаа галт тэрэг, цувааны нэгээс нөгөө рүү үсрэхийг хориглоно.
- Өргөж, зөөвөрлөж буй чингэлгийн дор зогсох, өргөөстэй байгаа чингэлэгт гаалийн шалгалт хийхийг хориглоно. Мөн гүүрэн кранаас болгоомжлон ачаа зөөвөрлөж байгаа үед холуур тойрно.
- Гаалийн үзлэг шалгалт хийхдээ чингэлгийг өргөгч цамхаг ажиллаж байгаа бүсээс гаргаж байрлуулна.
- Чингэлэгийн хаалгыг онгойлгох үед аюулгүй зайд зогсож, хаалгыг бүрэн нээсний дараа гаалийн хяналт шалгалтыг эхэлнэ.
- Чингэлэгээс ухарч гарч байгаа автомашин болон ачаа буулгаж байгаа өргөгчөөс болгоомжлоно.

2.1.4 Автотээврийн хэрэгсэл, түүгээр тээвэрлэгдэж буй бараанд гаалийн хяналт шалгалт хийхдээ:

- Автомашинаас бараа буулгах үзлэгийн тавцан дээр гарахдаа тавцангийн ирмэгт хэт ойрхон зайд зогсохыг хориглоно.
- Автомашины ачаа шалгах үзлэгийн тавцан дээр гарахдаа шатны бариул, хамгаалалтын хашлага байгаа эсэхийг шалгаж, халтирч унахаас болгоомжлоно.
- Ачааны тэвшнээс дээш ачсан өндөр ачааг шалгах үед бөх бат хийсэн шат, тэвштэй тэнцүү өндөрлөгтэй бэхлэгдсэн тавцанд буулгаж, ачаа нурж унахаас болгоомжлон ажиллана.
- Ачааны автомашины тэвшийг буулгахдаа дээр нь гарч, түгжээг мултлахыг хориглоно. Тэвшийг буулгахдаа дээрээс ачаа унаж, даруулах, цохиулахаас сэрэмжилнэ.
- Автотээврийн хэрэгсэл, түүн дээр ачигдсан бараанд гаалийн хяналт шалгалтыг хийхдээ аюулгүй байдлыг тэмдэглэсэн замын тэмдэг, тэмдэглэгээ, өргөх, буулгах механизм, тээврийн хэрэгслийг гаргаж зогсоох болон, доогуур нь орж шалгах тусгайлан бэлтгэсэн нүх бүхий тусгайлан тоногдсон талбайд явуулна.
- Тээврийн хэрэгслийг гаргаж зогсоон шалгах зориулалт бүхий тавцан нь хажуугаар нь унахаас хамгаалсан хаалттай байхаас гадна орж, гарах гарцтай байна.
- Өвлийн улиралд талбайн цасыг сайтар цэвэрлэж, элс, давс цацсан байна.
- Автотээврийн хэрэгслийн хөдөлгүүрийг бүрэн унтрааж, зогссоны дараа гаалийн хяналт шалгалтыг хийнэ.
- Гаалийн хяналт шалгалт дуусахаас өмнө тээврийн хэрэгслийн хөдөлгүүрийг асаах, хөдөлгөхийг хориглоно.

- Гаалийн хяналт шалгалт явуулж дуусаагүй байхад автомашиныг асаах, хөдөлгөхөөс урьдчилан сэргийлэх үүднээс автомашины кабинд хүн байхыг хориглоно.
- Автомашины түлхүүрийг хариулж, арааг салгасан, гар тормоз татсан байхыг шаардана.
- Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөн дунд тээврийн хэрэгслийн их бие, чиргүүлд шалгалт хийхийг хориглоно.
- Автомашины тэнхлэгийг толь тусгаж шалгахдаа автомашинд ивүүр тавьж, автомашиныг бүрэн унтрааж зогсоосон байна.
- Тээврийн хэрэгслийн дугуйг тайлж, гаалийн хяналт шалгалт хийхдээ машины дор зориулалтын тулгуур байрлуулж, тайлаагүй дугуйны дор ивүүр байрлуулсан байна.
- Ивүүр байрлуулахгүйгээр зөвхөн өргөх механизмаар /домократ, таль гэх мэт/ өргөсөн үед тээврийн хэрэгслийн доогуур орж үзлэг, шалгалт хийхийг хориглоно.
- Өргөсөн машины дор дугуйн обуд, тоосго гэх мэтийн зориулалтын бус зүйлээр тулгуур хийхийг хориглоно.
- Автотээврийн хэрэгслийн эд анги, хэсгүүдийг шалгахдаа эд ангийг нээлгүүлэх, салгуулах зэрэг үйлдлийг зөвхөн тухайн тээврийн жолооч хийнэ.
- Цас, мөс, бороо, мөндөрийн улмаас газрын доорхи ус нэмэгдэх болон үер буух эрсдэлтэй үед хамгаалалтгүй газарт тээврийн хэрэгслийг зогсоохгүй байх, тохиромжтой газарт байршуулсны дараа тээврийн хэрэгслийг шалгахдаа тухайн тээврийн хэрэгслийн кабин, кузов, чиргүүл рүү орж, гарахдаа анхаарал болгоомжтой ажиллана.
- Битүү машины хаалгыг нээх, ачаатай тээврийн хэрэгслийг шалгахдаа тухайн бараа дээрээс нурж, дарахаас сэргийлэх, хаалга, хаалт, цонхыг нээхдээ аюулгүй зайд байрласан байх, өндөр ачаатай тээврийн хэрэгслийг шалгахад зориулалтын шат, өргөх төхөөрөмжийг ашиглана.
- Бараа, автотээврийн хэрэгсэлд гаалийн хяналт шалгалт хийх газар нь бусад тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд саад учруулахгүй, мөн харагдахуйц ил газар зохих тэмдэг, тэмдэглэгээтэй байна.
- Гаалийн хяналт шалгалт хийхдээ автомашины хөдөлгүүр, кузов, цахилгааны халсан эд ангид түлэгдэхээс урьдчилан сэргийлж ажиллана.

2.1.5 Агаарын тээврийн хэрэгсэл, түүгээр тээвэрлэгдэж буй бараанд гаалийн хяналт шалгалт хийхдээ:

- Нислэгийн талбай дээр ажиллахдаа цацруулагчтай мөрөвч, хантааз тогтмол өмсөх, малгайг ердийн сонсгол хаахааргүй өмсөнө.
- Нисэх онгоц талбайд бүрэн зогсож, сэнс, хөдөлгүүрээ унтраахаас өмнө очихыг хориглоно.
- Нисэх онгоц тээшнээс ачаа туузан замаар бууж, зөөврийн тээврийн хэрэгсэлд ачих хооронд болон тээш, нээлхийд гаалийн хяналт шалгалт хийхдээ ачаа нурж унахаас болгоомжлоно.
- Нисэх онгоцны сэнс, их биеийн доогуур хөндлөн гарах болон агаарын хөлгийн чирэх, түрэх, хөдөлгүүр асаах үед 5 метрээс дотогш ойртохыг хориглоно.
- Сумалгааны үед шатахуун, тослох материалаас болгоомжилж, тамхи татах, шүдэнз зурах зэргээр ил гал гаргахыг хориглоно.

- Онгоц дотор гаалийн хяналт шалгалт хийхдээ эд зүйлс нурж унахаас болгоомжлоно.
- Нисэх талбайд ажиллагсад нь зөвхөн албан ажлын зорилгоор, албаны үнэмлэхээр нэвтэрнэ.
- Нисэх талбай дээрх механикжсан тээрийн хэрэгсэл, агаарын хөлгийн хөдөлгөөнийг анхааралтай тогтмол хянана.
- Онгоц болон нисэх онгоцны талбай дээр явж буй тээврийн хэрэгсэл, механикжсан хэрэгслийн хөдөлгөөн дунд буух, суух, тэдгээрийн өмнүүр гүйхийг хориглоно.
- Нисэх талбайн бүсийн хязгаарласан, хориглосон хаалт, тэмдэгтэй газраар нэвтрэхийг хориглоно.
- Хөдөлж байгаа агаарын хөлгийн өмнүүр болон араар 100 метрээс багагүй зайд явна.
- Нисэх онгоцны радарын системийг шалгаж байгааг илэрхийлсэн гэрэл ассан, онгоц тэнхлэгийн дагуу зогссон үед түүнийг хөндлөн гарахыг хориглоно.
- Нисэх онгоцны тавцан дээр зөвхөн зориулалтын дагуух тусгай шатаар гарах бөгөөд шөнө болон үзэгдэх орчин хязгаарлагдмал үед шат нь гэрэлтүүлэгтэй байна. Цас, мөсөөр хучигдсан, тослог зүйлс асгарсан шат ашиглахыг хориглоно.
- Нисэх онгоцонд гаалийн хяналт шалгалт хийхдээ багийн төлөөлөгчийг байлцуулна. Нисэх онгоц, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн аль ч хэсэгт зөвхөн нисэх инженер буюу нислэгийн механикчийн тусламжтайгаар гаалийн хяналт шалгалтыг хийнэ.
- Ачаалах болон буулгах үйл ажиллагаа явуулахад нисэх онгоцны нээлттэй хаалганы нүх, түүнчлэн өргөх барааны дор байхыг хориглоно.
- Барааны үзлэгийг нислэгийн талбайд хийхгүй, тусгайлан заасан газарт хийнэ.
- Ажиллаж байгаа механизм, цахилгааны сүлжээ зэргийг шалгахыг хориглоно.

2.1.6 Улс хоорондын шуудан, илгээмжид гаалийн хяналт шалгалт хийхдээ:

- Улс хоорондын шуудан, илгээмжид гаалийн хяналт шалгалт хийхдээ 2014 онд Монгол Улсын сайд, Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газрын дарга, Сангийн сайдын хамтарсан тушаалаар батлагдсан “Улс хоорондын шуудангийн илгээмжийг гаалийн хилээр нэвтрүүлэх журам” болон ХАБЭАЗ-г сахиж мөрдөнө.
- Улс хоорондын шуудан, илгээмжийг шуудангийн байгууллагын зориулалтын техник хэрэгслээр тусгайлан тоноглож бэлдсэн байр, талбайд хийнэ.
- Шуудан, илгээмжийг зориулалтын ширээ, тавцан дээр тавьж байрлуулсны дараа нээж шалгана.
- Шуудан, илгээмжид хортой, аюултай химийн бодис, тэсэрч дэлбэрэх бодис, цацраг идэвхит бодис түүнийг агуулсан бүтээгдэхүүн байгаа гэх мэдээлэлтэй эсхүл тийм сэжиг бүхий тохиолдолд уг илгээмжийг бусад илгээмжээс тусгаарлан, учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авсаны үндсэн дээр “Чанарын гарын авлагад заагдсан Аюулгүй ажиллагааны дүрэм”-ийн дагуу гаалийн хяналт шалгалт хийнэ.
- Гаалийн хяналт шалгалтаар илэрсэн үл танигдах /хортой эсэхийг үл мэдэх/ бодисыг асгарах, хагарч тархах, дэлбэрэхээс хамгаалан доргилтоос сэргийлж, давхар битүүмжлэн лабораторид шилжүүлнэ.

- Илгээмжийг дамжуулагч, зөөвөрлөгч механижсан төхөөрөмж дээр гарч зогсох, суухыг хориглоно.
- Ачаа зөөвөрлөх зориулалттай цахилгаан шатаар зорчихыг хориглоно.
- Илгээмж зөөвөрлөх, дамжуулах техник хэрэгслийн хөдөлгөөнд дэмжлэг үзүүлэхээр түлхэх, татах зэрэг үйлдэл хийхийг хориглоно.

2.1.7 Аюултай ачаанд гаалийн хяналт шалгалт хийхдээ:

- Аюултай шинж чанар бүхий бодис, объект, тоног төхөөрөмжид гаалийн хяналт шалгалт хийхдээ онцгой анхаарал болгоомжтой байж, урьдчилан тухайн шалгах барааны талаарх мэдээллийг бүрэн авсны дараа шалгалтыг хийнэ. Шаардлагатай тохиолдолд холбогдох мэргэжилтний туслалцаа авч болно.
- Аюултай ачааг тээвэрлэж буй тээврийн хэрэгсэл, байрлаж, агуулж байгаа агуулах, чингэлэг, байр талбайд гаалийн хяналт шалгалт эхлэхээс өмнө агааржуулалт хийсэн байна.
- Ажилтан аюултай ачаанд гаалийн хяналт шалгалт хийхэд урьдчилан аюулгүй ажиллагааны зааварчилгаа авч, зориулалтын хамгаалах хувцас, хэрэгсэлтэй байна.
- Аюултай ачааг шалгах үедээ, түүний ойр орчимд тамхи татах, ил гал гаргахыг хориглоно.
- Шатамхай бодис тээвэрлэж байгаа автоцистерний тагийг нээхдээ цохилтонд өртөж, гэмтэхээс урьдчилан сэрэмжилж болгоомжтой ажиллана.
- Гаалийн хяналт шалгалтын явцад аюултай, хортой шинж чанар бүхий бодис бараа болох нь мэдэгдвэл ажилтан аюулгүй байдлын боломжит бүх арга хэмжээг авах ба шаардлагатай тохиолдолд холбогдох мэргэжилтнийг дуудна.
- Хэрэв гаалийн бүрдүүлэлт, хяналт шалгалтын явцад сав, баглаа, боодол гэмтсэн, аюултай бодис асгарсан гэх мэт байдлаар тархсан байвал тээврийн байгууллага эсхүл холбогдох байгууллагаас хор аюулыг арилгах хүртэл гаалийн хяналт шалгалтыг тэр даруй зогсооно.
- Аюултай ачаанд гаалийн хяналт шалгалт хийхдээ зориулалтын хамгаалах хувцас, бээлий, хэрэгсэлтэй байх бөгөөд шалгалтын явцад хувцас, бээлий, хэрэгсэл аюултай бодисоор бохирдсон бол тэдгээрийг нэн даруй тайлна.

2.1.8 Химийн аюултай болон хорт бодисоос дээж авахдаа:

- Гаалийн хяналт шалгалт хариуцсан гаалийн улсын байцаагч нь дээжлэлт хийх гэж буй химийн бодисын холбогдох бичиг баримт болон аюулгүй ажиллагааны зааварчилгаатай танилцаж, тухайн бодисын талаар тодорхой мэдээлэл олж авсаны дараа дээж авна.
- Мөн гаалийн лабораториос гаргасан химийн бодисоос дээж авах аргачлалыг уншиж танилцсан байна.
- Химийн бодисоос дээж авахдаа зориулалтын хувцас, хамгаалах хэрэгсэл /бээлий, амны хаалт, нүдний шил, хормогч/-ийг өмсөж, багаж, хэрэгслийг ашиглан дээжлэлт хийнэ.
- Дээж авч буй сав нь тухайн барааны үндсэн төлөв байдал, шинж чанарыг алдагдуулахгүй зориулалтын материалаар хийгдсэн, цэвэр, хуурай байх шаардлагатай.

- Дээж авахдаа тухайн савыг 90%-ийн дүүргэлттэй авч, битүүмжлэн гаалийн лабораторид хүргүүлнэ.
- Шаардлагатай тохиолдолд тухайн барааг улсын хилээр нэвтрүүлсэн аж ахуйн нэгж болон салбар лабораторийн шинжээч гаалийн улсын байцаагчаас дээжлэлт хийх тухай мэргэжил арга зүйн зөвлөгөө авч болно.

ХОЁР. ЭРЭЛЧ НОХОЙН СУРГАЛТ БОЛОН ЭРЭЛЧ НОХОЙ ХАРИУЦСАН ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ НАРЫН ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ЗААВАРЧИЛГАА

2.2 2013 оны ГЕГ-ын даргын А/225 дугаар тушаалаар батлагдсан “Албаны эрэлч нохойг гаалийн хяналт шалгалтад ашиглах заавар” болон ХАБЭАЗ-г мөрдөж ажиллана.

- Нохойтой ажиллахаас өмнө аюулгүй ажиллагааны зааврыг холбогдох албан тушаалтнаас авч, гарын үсэг зурж, баталгаажуулна.
- Гаалийн албаны эрэлч нохойг мэргэжлийн бус хүнд шилжүүлэх, хариуцуулахыг хориглоно.
- Албаны эрэлч нохойгоор өндөр настан, жирэмсэн эмэгтэйчүүд, тахир дутуу болон насанд хүрээгүй хүмүүсийн биед биет шалгалт хийх, айлгахыг хориглоно.
- Албаны эрэлч нохойгоор гаалийн хяналт шалгалт хийхдээ авто тээврийн хэрэгслийг бүрэн зогсоогүй байхад үзлэгт оруулахыг хориглоно.

2.2.1 Албаны эрэлч нохойг ашиглан бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт шалгалт хийхдээ:

- Албаны эрэлч нохойгоор бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт шалгалт хийхдээ хүзүүвч, хөтөлгөө, хошуувчтай үүрэг гүйцэтгэнэ.
- Тээврийн хэрэгслийн хөдөлгөөн бүрэн зогссон хойно хөдөлгөөнт хяналтын гаалийн улсын байцаагч албаны эрэлч нохойгоор гаалийн хяналт шалгалтыг эхлүүлнэ.
- Албаны эрэлч нохойгоор гаалийн хяналт шалгалтыг хийхдээ барааг албаны эрэлч нохой бүрэн үнэртүүлэх хэмжээнд байрлуулсан, авто тээврийн хэрэгслийг тэгш газар зогсоож, зорчигч нарыг бараа, тээврийн хэрэгслээ харж болох зайд байршуулсан байна.
- Тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт шалгалт хийхэд зориулалтын нүхэн гарцгүй газарт хөдөлгөөн бүрэн зогсож, тээврийн хэрэгсэл бүрэн унтарсан байна. Доороос дээшээ, дотроос гадагшаа гэсэн дарааллаар гаалийн хяналт шалгалтыг хийнэ.
- Эрэлч нохойгоор хяналт шалгалт хийхдээ тээврийн хэрэгслийн халсан эд ангид эрэлч нохой түлэгдэхээс урьдчилан сэргийлнэ.

2.2.2 Албаны эрэлч нохойг ашиглан нисэх онгоцонд гаалийн хяналт шалгалт хийхдээ:

- Нисэх онгоцны зорчигчийн танхим, нисэх бүрэлдэхүүний хэсэгт албаны эрэлч нохойгоор гаалийн хяналт шалгалтыг хийнэ.
- Сэжиг бүхий илгээмж, ачаанд албаны эрэлч нохой ашиглан гаалийн хяналт шалгалтыг хийхдээ өөрийн болон албаны эрэлч нохойн аюулгүй байдлыг хангах үүднээс болгоомжтой харьцана.

- Зорчигчийн танхим, зорчигчийн гар тээшинд гаалийн хяналт шалгалтыг хийхдээ албаны эрэлч нохойд хүзүүвч, хөтөлгөө, хошуувчтай ажиллуулна.

2.2.3 Албаны эрэлч нохойг ашиглан улс хоорондын шуудан, илгээмжид гаалийн хяналт шалгалт хийхдээ:

- Дипломат төлөөлөгчийн газар болон түүнтэй адилтгах бусад байгууллагын бараанд гаалийн хяналт шалгалт явуулахдаа Гаалийн тухай хуулийн 220, 221 дүгээр зүйлийг баримтлан үүрэг гүйцэтгэнэ.

2.2.4 Албаны эрэлч нохойг ашиглан галт тэргэнд гаалийн хяналт шалгалт хийхдээ:

- Гаалийн албаны эрэлч нохойг тээврийн хэрэгслийн тамбур дээр суулган байршуулсан байна.
- Зорчигч болон галт тэрэгний үйлчлэгч нарын аюулгүй байдлыг хангаж, албаны эрэлч нохойтой болгоомжтой харьцахыг сануулж, тухайн бүсийг өөрийн хяналтад авч ажиллана.
- Зөөлөн суудал болон зорчигчдын амрах хэсэг, ачааны хэсэг болон зүтгүүр, машинистын кабин, узель, эзэнгүй дайвар ачаанд албаны эрэлч нохойгоор нарийвчилсан үзлэг шалгалтыг хийнэ.

2.2.5 Албаны эрэлч нохойг зөөж, тээвэрлэхдээ:

Албаны эрэлч нохойг амрах үүрнээс нь хяналтын бүс рүү шилжүүлэн байршуулах буюу нэг гаалийн газар, хорооноос нөгөө гаалийн газар, хороодод шилжүүлэхэд дараах байдлаар аюулгүй зөөвөрлөнө. Үүнд:

Эрэлч нохойг галт тэргээр зөөвөрлөх үеийн аюулгүй ажиллагаа

- Эрэлч нохойг тусгай зориулалтын зөөврийн үүрэнд байрлуулах ба үүрний гадна талд “Анхаар нохой зорчиж байна” гэсэн тэмдэглэгээ бүхий наалтыг наасан байна.
- Зөөврийн үүрэнд байрлуулсан эрэлч нохойг галт тэрэгний тээшинд хамгийн сүүлд хүлээлгэн өгнө.
- Тээшний хэсэгт байрлуулан ачихдаа ачигч нарт зөөлөн өргөж, буулгах мөн зөөврийн үүрэн дээр ачаа, бараа тавихгүй байхыг сануулна.
- Эрэлч нохойг зөөврийн үүрэнд хийж зөөвөрлөхөөс 18 цагийн өмнө хооллож , 3 цагийн өмнө усалж, 30 минутын өмнө бие засуулсан байна.

Эрэлч нохойг нисэх онгоцоор зөөвөрлөх үеийн аюулгүй ажиллагаа

- Эрэлч нохойг тусгай зориулалтын зөөврийн үүрэнд байрлуулах ба үүрний гадна талд “Анхаар нохой зорчиж байна” гэсэн тэмдэглэгээ бүхий наалтыг наасан байна.
- Зөөврийн үүрэнд байрлуулсан эрэлч нохойг нисэх онгоцны тээшинд хамгийн сүүлд хүлээлгэн өгнө.
- Тээшний хэсэгт байрлуулан ачихдаа ачигч нарт зөөлөн өргөж, буулгах мөн зөөврийн үүрэн дээр ачаа, бараа тавихгүй байхыг сануулна.
- Эрэлч нохойг зөөврийн үүрэнд хийж зөөвөрлөхөөс 18 цагийн өмнө хооллож , 3 цагийн өмнө усалж , 30 минутын өмнө бие засуулсан байна.

Эрэлч нохойг автомашинаар зөөвөрлөх үеийн аюулгүй ажиллагаа

- Эрэлч нохойг тусгай зориулалтын зөөврийн үүрэнд байрлуулах ба үүрний гадна талд “Анхаар нохой зорчиж байна” гэсэн тэмдэглэгээ бүхий наалтыг наасан байна.
- Автомашины тээшний хэсэгт зөөврийн үүр багтахгүй байгаа тохиолдолд эрэлч нохойг хүзүүвч, хөтөлгөөний хамт тээшний хэсэгт хийнэ.
- Эрэлч нохойг зөөвөрлөхөөс 18 цагийн өмнө хооллож, 3 цагийн өмнө усалж, 30 минутын өмнө бие засуулсан байна.
- Шилжүүлэн зөөх үед 2 цаг тутамд автомашиныг зогсоож, эрэлч нохойг буулгаж, салхилуулан усалж, эргүүлэн зөөвөрлөнө.

Эрэлч нохойг хотод болон хот хооронд нийтийн тээврийн хэрэгслээр зөөвөрлөх үеийн аюулгүй ажиллагаа

- Эрэлч нохойг нийтийн тээврийн хэрэгслээр зөөвөрлөхдөө хүзүүвч, хөтөлгөө, хошуувч, хантаазыг зүүлгэсэн байна. Мөн эрэлч нохой хариуцсан албан хаагч эрэлч нохойг суу эсвэл хэвт команд өгч зөөвөрлөнө.
- Эрэлч нохойг хариуцсан албан хаагч эрэлч нохойг зөөвөрлөх үеийн бүхий л үе шатанд өөрийн биеэр хяналт тавин оролцоно. Гадны хүнийг эрэлч нохойд ойртохгүй байх санамжийг байнга анхааруулан хэлнэ. Мөн албаны эрэлч нохойн хувийн хэргийг эрэлч нохойн хамт байнга авч явна.

2.2.6 Албаны эрэлч нохойг сургахдаа:

Албаны эрэлч нохойг сургаж, бэлтгэх үед сургагч нь дараах аюулгүй ажиллагааны зааврыг дагаж мөрдөнө. Үүнд:

- Албаны эрэлч нохойн үүрэнд орох, хооллох болон услахдаа айлгаж, цохихгүй байна.
- Сургалтад хамрагдаж байгаа үед ноходыг сул тавихгүй байна.
- Сургагч нь нохойнд хазуулж, уруулахаас сэргийлж, зузаан материалтай өмд, цамц, бээлий, хагас түрийтэй гутал хэрэглэнэ.
- Нохойн үүрэнд гадны хүн оруулахыг хориглоно.
- Нохойн үүрийг цэвэрлэхдээ бээлий, амны хаалт, малгай хэрэглэнэ.
- Нохойтой ажилласны дараа гутлын ул, хувцас болон гар, нүүрийг угааж, ариутгана.
- Сургалтад ашиглагдаж байгаа үнэрүүдэд дур мэдэн бээлийгүй гараар хүрэхийг хориглоно.
- Өөрийн сургаж байгаа нохойноос өөр нохой руу шаардлагагүй тохиолдолд ойртохгүй байна.
- Сургалтын үед эрэлч нохойнд хүзүүвч, хөтөлгөөг байнга хэрэглэнэ. Зайлшгүй тохиолдолд хошуувч хэрэглэнэ.

ГУРАВ. РЕНТГЕН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ ХАРИУЦСАН ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧИЙН ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ЗААВАРЧИЛГАА

2.3 Рентген төхөөрөмжөөр зорчигчийн биед үзлэг хийх, ачаа тээш, чингэлэг, ачааны болон суудлын автомашин, галт тэрэг шалгах, лабораторийн шинжилгээний зориулалттай рентген үүсгүүрээр гаалийн хяналт, шалгалтыг хийхэд болон болзошгүй ослын үед авах арга хэмжээг “Хөтөлбөр, дүрэм, төлөвлөгөө батлах

тухай” ГЕГ-ын даргын 2019 оны А/82 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Гаалийн байгууллагын цацрагийн хамгаалалтын хөтөлбөр”, 2 дугаар хавсралтаар батлагдсан “Гаалийн хяналт шалгалтад рентген төхөөрөмж ашиглах үед дагаж мөрдөх цацрагийн аюулгүй ажиллагааны дүрэм”, 3 дугаар хавсралтаар батлагдсан “Цацрагийн болзошгүй ослын үед авах арга хэмжээний төлөвлөгөө”-г мөрдлөг болгоно.

---oOo---

ЗААВАРЧИЛГАА №3

НЭГ. ЛАБОРАТОРИЙН ДАРГА, АХЛАХ ШИНЖЭЭЧ ГААЛИЙН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ, ШИНЖЭЭЧ ГААЛИЙН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ, ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ, НЯРАВ-ЛАБОРАНТЫН ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ЗААВАРЧИЛГАА

3.1 Гаалийн төв болон салбар лабораторийн ажиллагсад нь магадлан шинжилгээ хийхдээ “Менежментийн тогтолцооны эрх зүйн бичиг баримт” болон “Магадлан шинжилгээ хийх, дүгнэлт гаргах журам”-ыг мөрдлөг болгож ажиллана.

- Лабораторийн шинжээч нар нь шинжилгээ хийж эхлэхийн өмнө “Химийн лабораторийн аюулгүй байдлын дүрэм”-ийг уншиж танилцан, гарын үсэг зурсан байна.
- Лабораторид ажиллагсад нь хувийн хамгаалах хэрэгсэл /халад, бээлий, амны хаалт, хормогч, нүдний шил, лабораторийн зориулалтын гутал/-ийг өмсөж хэвшсэн байх шаардлагатай.
- Хувийн хамгаалах хэрэгслүүд нь хүчил, шүлт болон дулаанд тэсвэртэй материалаар хийгдсэн байна.
- Лабораторид ажиллагсад нь химийн бодисын хорыг саармагжуулах зорилгоор сүү болон бусад ундаа, хүчилтөрөгчийн коктейль хэрэглэнэ.
- Лабораторид ажиллаж байгаа хүн бүр дараах дүрэм, журмуудыг сайтар мөрдөнө. Үүнд:
 - Химийн урвалж бодистой ажиллах, хадгалах дүрэм,
 - Галын аюулгүй байдлын дүрэм,
 - Цахилгааны аюулгүй байдлын дүрэм.
- Лабораторийн шинжилгээний өрөө тасалгаанд гадны хүн, зөвшөөрөлгүй нэвтрэхийг хориглоно.
- Шаардлагатай тохиолдолд лабораторид нэвтрэхдээ зөвшөөрөл авч, хувийн хамгаалах хэрэгсэлтэй болон хөдөлмөр хамгааллын зааварчилгаа авсан хүнийг нэвтрүүлнэ.
- Лабораторийн шинжилгээнд хамрагдсан химийн хорт болон аюултай бодисын дээжийг хариуцагч аж ахуйн нэгж болон иргэнд хүлээлгэн өгөхдөө, хүлээлгэн өгсөн тухай тэмдэглэл заавал үйлдэж, дээжийг зориулалтын бус газарт хаяж, орхихгүй байх талаар анхааруулга санамж өгнө.
- Лабораторийн өрөө тасалгаа болон хүрээлэн буй орчинд нь химийн хорт болон аюултай бодис дэгдсэн, үнэр нь тархсан байвал өрөө тасалгааг агааржуулж, зориулалтын агааржуулах системийг нэн даруй ажиллуулж, болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэхийн тулд орчин тойрныг чөлөөлөх арга хэмжээ авна.
- Лабораторийн шинжилгээний ажил дууссанаар тухайн өдрийн жижүүр өрөөнүүдийг шалган, цахилгаан хэрэгслийг салган, өрөөнүүдийг лацдан харуулд хүлээлгэн өгнө.

---oOo---

ЗААВАРЧИЛГАА №4

НЭГ. ҮЙЛЧИЛГЭЭ, АЖ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР АЖИЛЛАХ АЛБАН ХААГЧДЫН ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ЗААВАРЧИЛГАА

4.1 Үйлчилгээ, аж ахуйн чиглэлээр ажиллах албан хаагчид нь Хөдөлмөрийн гэрээнд заагдсан ажил үүргийг гүйцэтгэхдээ ХАБЭАЗ-г дагаж мөрдөнө.

4.1.1 Цогцолборын менежер, аж ахуйн үйл ажиллагаа хариуцсан зохион байгуулагч, спорт заалны менежер ажил үүргээ гүйцэтгэхдээ:

- Ажлын байр, автогараж болон орон сууцны байруудыг дулаанаар, цэвэр усаар хангах, цахилгаан хангамж, сантехникийн болон бусад засвар, үйлчилгээг үзүүлэх, харуул хамгаалалт тээврийн хэрэгслийн найдвартай, бэлэн байдлыг хангаж ажиллана.
- Дулааны улиралд хийгдэх, дулаан, цахилгаан, цэвэр, бохир ус, сантехникийн засварын ажлыг графикийн дагуу гаргаж, удирдлагад танилцуулан, шаардлагатай засварын ажлыг хийхдээ аюулгүй байдалд анхаарна.
- Үндсэн хөрөнгийн ашиглалт, хадгалалтад хяналт тавих, контор, автогаражийн камер, гэрэлтүүлэг, хаалга, цоожийг бүрэн бүтэн байлгана.
- Автогаражид тавьж байгаа машинуудад хяналт тавьж ажиллана. Зөвшөөрөлгүй машин гаражид тавиулахыг хориглоно. Галын аюулгүй байдлыг хангаж, галын хор, гал унтраах бусад хэрэгслэлийн буланд шаардлагатай эд зүйлсийг байлгаж, харуулд хүлээлгэн өгнө.
- Харуул, жолооч, үйлчлэгч, цахилгаанчин, сантехникч, галч, сахиул, мужаан зэрэг төрийн үйлчилгээний албан хаагчдын ажилд тогтмол хяналт тавьж, санамж, зөвлөгөө өгч ажиллана.
- Байгууллагын гадна талын өнгө, үзэмжинд хяналт тавьж, цэвэрлэгээг үйлчилгээний ажилтнуудаар хийлгэж, хогийг тогтмол хугацаанд ачуулсан байна. Гадна орчны цэвэрлэгээг хийхдээ өнжмөл өвс, хог шатаахыг хориглон, гал түймрээс урьдчилан сэргийлж ажиллана.
- Төрийн үйлчилгээний албан хаагчид ажил үүргээ гүйцэтгэхдээ хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдлыг хангасан ажлын хувцас, хэрэглэлээр хангагдаж байгаа эсэхэд болон өдөр тутам албан үүргээ гүйцэтгэхдээ хувцас, хэрэглэлээ өмсөж, хэрэглэж байгаад тогтмол хяналт тавина.
- Биеийн тамирын зааланд зохион байгуулагдаж байгаа үйл ажиллагааны (тэмцээн, уралдаан, хурал, цуглаан) үед аюулгүй ажиллагааг хариуцан зааланд хэрэглэгдэж байгаа техник хэрэгслийн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж ажиллана.
- Цогцолборын буудалд зочид буудлын үйл ажиллагаа хариуцан, зочид буусан бол тухай бүр удирдлагад мэдэгдэж, зочдод өөрийн биеэр буудлын өрөөг хүлээлгэн өгч, буудлаас гарахад нь мөн хүлээж авна. Зочдод аюулгүй байдлын санамж, зөвлөгөө өгнө.

4.1.2 Нярав, номын санч-нярав, үнэт цаас, мөнгөн касс, аж ахуй хариуцсан нярав, УОБ, тооцоот хуудас хариуцсан нярав ажил үүргээ гүйцэтгэхдээ:

- Өглөө ажлын байранд ирээд цахилгаан хэрэгслүүдийг (компьютер, хэвлэгч, хувилагч, агааржуулагч гэх мэт) асааж, бүрэн бүтэн, хэвийн ажиллаж байгаа эсэхийг шалгана.
- Агуулах болон номын санд галын хор, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх самбар байршуулж, шүдэнз зурах, лаа асаах гэх зэргээр гал гаргахыг хориглоно.
- Өрөө тасалгаанд галын аюулгүй байдлыг хангаж эвдрэл, гэмтэлтэй цахилгаан хэрэгсэл ашиглахгүй байх, үдийн цайны завсарлага болон ажил тарсан даруйд бүх цахилгаан хэрэгслийг залгуураас салган, галын аюулгүй байдлыг хангана.
- Үндсэн болон бусад эд хөрөнгийн бүртгэл, тэдгээрийн хамгаалалт, хадгалалт, ашиглалтад хяналт тавих, бүрэн бүтэн байдлыг хангаж, засвар үйлчилгээг хийнэ.
- Улсын орлого болсон барааг нягтлан бодох бүртгэлд тусгах, барааг үнэлүүлэх, худалдан борлуулах, устгах, хадгалалтын үйл ажиллагааг зохион байгуулж, аюулгүй байдлыг хангана.
- Барааг устгахаар явахдаа холбогдох мэргэжлийн байгууллагын төлөөллийг заавал оролцуулж, хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн аюулгүй байдлыг хангаж, ажлын хувцас, хэрэгслийг /амны хаалт, бээлий гэх мэт/ өмссөн байна.
- Үнэт цаас, мөнгөн касс, тооцоот хуудасны хадгалалт, зарцуулалтад хяналт тавьж, үрэгдэхээс хамгаалан зориулалтын сейф, шүүгээнд хадгална.
- Ажил тарахад ажлын байрны цонхыг хааж, цахилгаан хэрэгслүүдийг залгуураас салган унтраасан эсэхийг шалгаж, өрөөг түгжин, заавал лац тавина.

4.1.3 Бага эмч ажил үүргээ гүйцэтгэхдээ:

- Эмчилгээний тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хариуцаж хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлж ажиллана.
- Зүү тариур, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн халдваргүйжүүлэлт, эрүүл ахуйн аюулгүй ажиллагааг ханган, стандарт нормыг мөрдөн хариуцлагатай ажиллана.
- Эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэхдээ амны хаалт, нэг удаагийн бээлий, халад, малгайг өмсөж, нэг удаагийн баталгаат зүү, тариурыг хэрэглэж, үйлчлүүлэгч солигдох бүрт гарыг ариутгаж, угаасан байна.
- Эмчилгээ хийж буй эмчийн өрөөнд 7 хоногт 1 удаа их цэвэрлэгээ, өдөр бүр 2%-ийн хлорамины уусмалаар чийгтэй цэвэрлэгээ хийж, L-30 маркын кварцаар 5-10 минут шарж ариутгаж байна.
- Эрүүл ахуй халдвар хамгааллыг сахих үүднээс эмчийн өрөөний цагаан хэрэглэлийг 7 хоног тутам угааж ариутгаж, эмчилгээ, үйлчилгээнд хэрэглэж буй алчуур болон багаж хэрэгслийг 2% хлорамины уусмалд угааж, ариутгана.
- Эмнэлгийн хог хаягдлыг тусгай зориулалтын уут, саванд ялган хийж, тусгай тээврийн хэрэгслээр тээвэрлүүлэн бүртгэл хөтлөнө.
- Нийт албан хаагчид болон үйлчлүүлэгч нарт эрүүл таатай орчинд ажиллах боломжийг бүрдүүлэх үүднээс цэвэрлэгээ, үйлчилгээнд хяналт тавин үйлчилгээний ажилчдад заавар, зөвлөгөө өгч хяналт тавина. (Ариун цэврийн өрөөнд тогтмол ариутгал хийлгэнэ.)

- Цайны газрын ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөл, хоолны дээжийн чанарт тогтмол үзлэг шалгалт хийж, хяналт тавьж ажиллана.
- Өдөр бүрийн цэвэрлэгээнд хлормины уусмал тогтмол хэрэглэнэ.

4.1.4 Цахилгааны инженер, цахилгаанчин, дизельчин, лифтчин нь ажил үүргээ гүйцэтгэхдээ:

- Цахилгааны инженер нь ашиглагдаж байгаа цахилгаан тоног төхөөрөмжүүдэд урьдчилан сэргийлэх үзлэг шалгалт, засвар үйлчилгээг хийж, цахилгаан тоног төхөөрөмжийн засварчин болон цахилгаанчин, дизельчинд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгааг өдөр бүр танилцуулан, гарын үсэг зуруулна.
- Байгууллагын цахилгаан хангамжийн их болон урсгал засварын ажил, цахилгааны шугам, сүлжээ, узель, болон бусад тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг байнга шалгаж засвар үйлчилгээ, баталгаажуулах ажлыг гүйцэтгэнэ.
- Байгууллагаас олгосон хөдөлмөр, хамгааллын хувцас, малгай, бээлий, нүдний шил, амны хаалтыг тогтмол өмсөж, ажилд шаардагдах зориулалтын багаж, хэрэгслийг ашиглана.
- Галын аюулгүй байдлыг хангаж, цахилгааны доголдлыг шуурхай засаж, хэвийн ажиллагаатай болгоно.
- Өндөр хүчдэлийн шон руу авирахдаа хөдөлмөр хамгааллын хувцсыг бүрэн гүйцэд өмсөж, зориулалтын дөрөөгөөр авирах, хамгаалалтын бээлий, хамгаалалттай багаж, хэрэгсэл хэрэглэж ажиллана.
- Байгууллагын барилга, объектийн цахилгааны холболт болон гэрэлтүүлгийн төхөөрөмж, ахуйн хэрэглээний цахилгааны хангамжийн хэвийн найдвартай ажиллагааг хангаж, мэргэжлийн түвшинд гүйцэтгэнэ.
- Осол аваараас сэргийлж, цахилгаан хэрэгсэлтэй ажиллах дүрмийг баримтлан, засвар, үйлчилгээ хийхдээ цахилгааныг бүрэн тасалж, засвар, үйлчилгээг эхлүүлнэ.
- Галын аюулаас урьдчилан сэргийлэх үзлэг шалгалтыг тогтмол хийж, авах арга хэмжээг удирдлагад танилцуулж, шийдвэрлүүлнэ.
- Лифтчин нь нэгжийн даргын зөвшөөрлөөр цахилгаан шатны засвар, үзлэг, үйлчилгээг тогтмол хийж, эд ангийг солино.
- Цахилгаан дамжуулах хэлхээний удирдлагын самбар, лифтний техникийн өрөө, хонгилд нэвтрэх хаалгыг цоожтой байлгах, засвар үйлчилгээ хийх үед “засвар хийж байна” гэсэн самбар байршуулж ажиллана.
- Лифтийг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрмийг баримталж ажиллана.
- Хариуцсан ажлын чиглэлээр гэнэтийн осол, гэмтэл гарсан үед удирдлагад яаралтай танилцуулан, байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлнэ.
- Хөдөлгүүрийг тогтмол цэвэрлэж, хөдөлгүүрийн их биеийн газардуулгыг шалгаж, бүрэн бүтэн байдлыг хангана.
- Гүйдэл дамжуулах, эргэлдэх хэсгүүдийг байнга хаалттай байлгана.
- Техникийн үзлэг хийх үед болон засвар хийх үед хөдөлгүүрийг шугамаас заавал салгасан байна.

- Хөдөлгүүрийг ажиллуулахын өмнө хүчдэл хэвийн хэмжээнд байгаа эсэхийг шалгаж үзнэ. Хэт их хүчдэлд залгахыг хориглоно.
- Шинэ буюу 1 сараас дээш хугацаагаар ажиллаагүй зогссон хөдөлгүүрийг ажиллуулахын өмнө тусгаарлагчийн эсэргүүцлийг хэмжиж, шалгаж, ажиллуулна.
- Хөдөлгүүрийг ажиллуулахдаа эхлээд асааж, ачаалал өгөхийн өмнө механик гэмтэл, доргилт, дуу чимээ байгаа эсэхийг шалгаж, хэвийн ажиллаж байгаа нөхцөлд ажиллуулна. Хэрэв хөдөлгүүрт гэмтэл илэрвэл гэмтлийг засаж, арилгасны дараа ажиллуулна.
- Хөдөлгүүрийг ажиллах явцад хөдөлгүүрийн бохирдол, механик хүчдэлийн холболтод байнгын хяналт тавьж ажиллана.
- Хөдөлгүүрийг залгуурт нойтон гар болон нойтон, чийгтэй даавуугаар жийрэглэх, нойтон чийгтэй бээлийтэй гараар барьж залгахыг хориглоно.
- Цахилгааны аюул ослоос урьдчилан сэргийлэх анхааруулах тэмдгүүдийг шаардлагатай газруудад байршуулсан байна.
- Өндөр хүчдэлийн шон руу авирахдаа хөдөлмөр хамгааллын хувцсыг бүрэн гүйцэд өмсөж, зориулалтын дөрөөгөөр авирах, хамгаалалтын бээлий, хамгаалалттай багаж, хэрэгсэл хэрэглэж ажиллана.
- Дизель станцын ажлын өрөөнд гадны хүн оруулахгүй байна. Дизель генераторыг асаахын өмнө орчин тойрныг шалгаж, эргэлдэх хэсэг, тогтоосон зайд хүн ойр байлгахыг хориглоно.
- Дизель ажиллуулж, генераторт сэргээлт өгөх, ачаалал авах үед сэлгэн залгалтыг дарааллын дагуу зөв гүйцэтгэнэ.
- Дизель станцын өрөөнд таслалт, залгалт, сэлгэн залгалт хийхдээ хамгаалах бээлий, багаж хэрэгсэлгүйгээр дээрх үйлдлүүдийг хийхийг хориглоно.
- Дизель генераторт дизель түлш нэмэхдээ, өөрийн бие рүүгээ асгахаас болгоомжилж, анхаарал болгоомжтой ажиллана.
- Хүчдэл дамжуулах хэсэгт ойртох зайг чанд баримталж, шаардлагатай тохиолдолд хүчдэлийг салгасны дараа ажиллана.
- Шатах, тослох материалын ойр орчимд ил гал гаргах, тамхи татахыг хориглоно.

4.1.5 Сантехникийн инженер, сантехникийн слесарь нь ажил үүргээ гүйцэтгэхдээ:

- Сантехникийн инженер нь ашиглагдаж байгаа сантехникийн тоног төхөөрөмжүүдэд урьдчилан сэргийлэх үзлэг шалгалт, засвар үйлчилгээг хийж, сантехникийн слесарьд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгааг өдөр бүр танилцуулан, гарын үсэг зуруулна.
- Байгууллагаас олгосон хөдөлмөр хамгааллын хувцас, гутал, малгай, бээлий, нүдний шил, амны хаалтыг тогтмол өмсөж, ажилд шаардагдах зориулалтын багаж, хэрэгслийг ашиглана.
- Үндсэн ажлын зэрэгцээ бусад байгууллагад өөр ажил хавсран гүйцэтгэхийг хориглоно.
- Ажиллах үед ажлын ширээг бөх бат, хөдөлгөөнгүй, ажил гүйцэтгэхэд эвтэй байхаар суурилуулсан байна.
- Ажлын багаж, хэрэгслийг ажил эхлэхээс өмнө шалгаж, гэмтэлтэй багажийг засаж, ажилд бэлэн болгоно.

- Гэрэлтүүлэг сайтай орчинд ажиллана.
- Зөөврийн цахилгаан гэрэл ашиглахдаа 6 вольтоос илүү хүчдэлтэйг хэрэглэхгүй байх, чийгтэй, нойтон орчинд 12 вольтоос илүү хүчдэлтэйг хэрэглэхийг хориглоно.
- Цахилгаан гагнуур хийхдээ хамгаалалтын баг, амны хаалтыг зүүсэн байна.
- Цахилгаан багажаар ажиллах үед хамгаалалтын бээлийг өмсөж, төмөр дээр зогсож, цахилгаан багажаар ажиллах бол хамгаалалтын резинэн дэвсгэр хэрэглэнэ.
- Урсгал болон их засвараар шугам хоолой солих үед хавтанд дарагдах, хавчуулагдах, краны дэгээ мултрах, тросс дэгээнд цохиулах, тросс тасрах зэрэгт анхаарал болгоомжтой ажиллана.
- Усны халаалтын тогоонд болон зуухны насоснууд, цахилгаан хөдөлгүүрүүд, хаалтнуудад гарч болох гэмтлүүдээс урьдчилан сэргийлнэ.
- Цэвэр усны даралт халаалтын өгөх, буцах шугамын даралт ба температурт байнга хяналт тавьж, өөрчлөлт гарсан тохиолдолд шалтгааныг тогтоож, гэнэтийн ослоос сэргийлж ажиллана.
- Засвар, үйлчилгээ хийхдээ мотор, хөдөлгүүрүүдийг бүрэн зогсоож, унтарсны дараа засварын ажлыг эхлүүлнэ.
- Уурын зуухны тогооны дотор талд цэвэр агаартай, 45 градусаас дээшгүй халуунтай байгаа үед халууны хэмжилт хийсний дараа засварын ажлыг эхлүүлнэ.
- Тогоон дотор засвар хийх шаардлага гарсан тохиолдолд ганцаараа ажиллахыг хориглох ба 2-оос доошгүй хүн ажиллана.
- Уурын зуухны утаа ба салхины хоолойд засварын ажлыг хийхдээ түүнд байгаа үнсийг урьдчилан зайлуулсан байна. Утаа, салхины хоолойд ажил гүйцэтгэх явцад утаа сорогч салхилуурыг ажиллуулахыг хориглоно.
- Ус шахалт хийж байхад гэмтэлтэй хаалтыг засах, даралттай үед хоолой ба хаалтыг тагласан битүү таглааны эсрэг байрласан гэмтлийг засахыг хориглоно.
- Мотор, хөдөлгүүрүүдийг газардуулга хийхгүйгээр ажиллуулахыг хориглоно.
- Сэнс, насос, мотор, хөдөлгүүрт засвар хийх тохиолдолд тэдгээрийг бүрэн зогсоож, унтраасны дараа засварын ажлыг эхлүүлнэ.
- Моторын эргэх хэсэгт нь хамгаалалтын бүрээс заавал хийсэн байна. Мотор ажиллаж байх үед моторын гэмтлийг засах, эргэх хэсэгт нь хийсэн хамгаалалт бүрээсийг авахыг хатуу хориглоно.
- Эргэх хэсэг нь ил, хамгаалалтгүй, гинжин ба резинэн дамжуулагчтай машин, механизмын дэргэд болон ойролцоо ажиллахыг хориглоно.
- Сэнс, насосыг ажиллуулахын өмнө дотор нь янз бүрийн бодис, засварын багаж түлхүүр, төрөл бүрийн жийргэвч, эрэг, боолт үлдсэн эсэхийг заавал шалгаж үзнэ.
- Яндан, хоолой болон арматуруудыг даралтаар шалгах үед ажлын байранд гадны хүн оруулахыг хориглоно. Даралтаар шалгаж байгаа хүмүүс аль болох аюул багатай байрыг сонгон авсан байна.
- Яндан хоолойг усаар шахаж шалгахдаа тогтоосон хэмжээнээс илүү гаргахгүй байна.

- Яндан, хоолой болон арматуруудыг даралтаар шалгахаас өмнө фланцан залгаагаар холбогдсон хаалт, вентилийн боолтуудыг шалгаж үзсэн, чангалсан байна.
- Эвдэрхий бөгөөд засвар хийсэн нь батлагдаагүй манометрээр даралт шалган үзэхийг хатуу хориглоно.
- Даралттай байх үед аливаа гэмтлүүдийг засахыг хориглоно.
- Худаг, траншей, сувагт ажиллах үед өдөр бүр шугам сүлжээ, дулааны болон бохирын усны худгуудын ажиллагааг шалгаж үзэн, шаардлагатай урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажиллана.
- Худаг, камерийн тагийг заавал дэгээгээр онгойлгож, хийг гаргаж, шууд орохыг хориглоно.
- Худаг дотор хуримтлагдсан тэсэрч, дэлбэрэх хорт хий байхаас болгоомжлох, худаг руу орохын өмнө тусгай лампаар шалган үзэж, шүдэнз зурах, цаас шатаах зэргээр ил гал гаргахыг хориглоно.
- Худагт батарей бүхий гэрэлтүүлэгч, шат тавцанг ашиглаж, тэдгээрийн бат бөх, бүрэн бүтэн байдлыг тогтмол шалгана.
- Татуургын худагт ариутгах ажил хийхдээ 20 минут тутамд нэг удаа худгаас гарч, 10 минут амарна.
- Худаг, камерт зөөврийн гэрэл хэрэглэхдээ 12 вольтоос илүү хүчдэлтэй гэрэл хэрэглэхгүй байна.

4.1.6 Хэвлэх цехийн инженер, хэвлэх цехийн ажилтан нь ажил үүргээ гүйцэтгэхдээ:

- Хэвлэх машин болон бусад тоног төхөөрөмжтэй харьцахдаа үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн аюулгүй байдал, техникийн баримт бичигт заасан нөхцөлийн дагуу тоног төхөөрөмжийг ажиллуулна.
- Байгууллагаас олгосон хөдөлмөр, хамгааллын хувцас, малгай, бээлий, нүдний шил, амны хаалтыг тогтмол өмсөж, ажилд шаардагдах зориулалтын багаж, хэрэгслийг ашиглана.
- Үйлдвэрлэлийн явцад химийн бодистой харьцахдаа аюулгүй байдлыг ханган ажиллана.
- Өрөө, тасалгаанд чийгшүүлэгч хэрэглэж, тоосжилт, тоосонцорын харшилд өртөхөөс өөрийгөө хамгаална.
- Хэвлэх цехэд галын хорыг тогтмол байршуулж, галын аюулаас сэргийлж ажиллана.

4.1.7 Архивын эрхлэгч, архивын ажилтан нь ажил үүргээ гүйцэтгэхдээ:

- Хадгаламжийн санд гал гаргах, тамхи татах, төрөл бүрийн цахилгаан халаагуур хэрэглэх болон тэсрэх, дэлбэрэх бодис, химийн бодис, хүнсний бүтээгдэхүүн зэрэг гадны зүйлс байрлуулахыг хориглоно.
- Хадгаламжийн нэгж, баримт бичгийг архивт хүлээн авах, шилжүүлэх, архивын үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгуулахдаа зориулалтын ажлын хувцас, халад, амны хаалт, бээлий, намхан өсгийтэй гутал өмсөнө.
- Хадгаламжийн нэгжийг хадгалж буй тавиурын өндөрт тохируулан шат ашиглаж, шат руу өгсөж, буухдаа анхаарал болгоомжтой байна.

- Өрөө, тасалгаанд чийгшүүлэгч хэрэглэж, тоосжилт, тоосонцорын харшилд өртөхөөс өөрийгөө хамгаална. Архивын эрхлэгч, ажилтнууд нь жилд 1-ээс доошгүй удаа эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан байна.
- Архивын баримт үдэх, хавтаслахад ашигладаг багаж, төхөөрөмжтэй ажиллахдаа анхаарал болгоомжтой байж, аюулгүй байдлыг хангаж ажиллана.
- Архивын баримтыг зориулалтын тавиурт эмх цэгцтэй, нурж унахааргүй байдлаар өрнө. Зориулалтын тавиур байхгүй тохиолдолд баримтыг шалаар өрөхийг хориглоно.
- Архивын ажил үйлчилгээ явуулдаг бүх өрөө тасалгаа, хадгаламжийн санд галын аюулаас урьдчилан сэргийлэх санамж, анхааруулга бичиж, гал унтраах анхан шатны багаж, хэрэгслийг авч ашиглах боломжтой нүдэнд харагдахуйц газар байрлуулсан байна.

4.1.8 Малын эмч, нохой маллагч нь ажил үүргээ гүйцэтгэхдээ:

- Эрэлч ноходод эрүүл мэндийн ерөнхий үзлэгийг өдөр бүр хийж, илэрсэн өвчин эмгэгийг эмчлэн эдгэрүүлнэ.
- Албаны нохойд шаардлагатай урьдчилан сэргийлэх тарилга, вакциныг тогтмол тарьж дархлаажуулна.
- Нохойн байранд мал эмнэлэг, ариун цэврийн үзлэгийг өдөр бүр явуулж, ариутгал, халдваргүйжилтыг тогтмол гүйцэтгэнэ.
- Албаны эрэлч нохдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулж, вакцин, тарилга, туулгалтыг хийж гүйцэтгэнэ.
- Албаны нохойтой харилцагсдын хувийн ариун цэврийг чанд сахиулна.
- Албанд шинээр орж буй нохдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулан, эрүүл мэндийн дэвтэр нээж, гэрчилгээжүүлнэ.
- Эрэлч нохойн сургалтын төвийн байр, сургалтын байр, нохойн үүр, сургалтын талбай, зугаалгын талбайд болон гаднах орчинд сард 1 удаа их цэвэрлэгээг хийж гүйцэтгэнэ.
- Эрэлч нохойг хооллох, гөлөг өсгөх, бойжуулах сургах, дадлагажуулах, салхилуулах, зугаалуулах ажлыг тогтмол хийж гүйцэтгэнэ.
- Албаны эрэлч нохдыг өдөр тутмын орц нормын дагуу хооллож, нохойн үүрийг өдөр бүр цэвэрлэж, үүрний цэвэр цэмцгэр, бүрэн бүтэн байдлыг ханган ажиллана.
- Эрэлч нохойн үүр, үүр орчимд ариутгал, халдваргүйжилтыг хийнэ.
- Албаны эрэлч нохдыг усанд оруулах, самнах зэрэг арчилгаа, маллагааг хийнэ.
- Нохойн арчилгаа, маллагаа, өнгө үзэмжтэй холбоотой тоног хэрэгсэл (хөтөлгөө, хүзүүвч, хошуувч, сам, шампунь, апорт г.м)-ийн бүрэн бүтэн байдалд хяналт тавьж, шаардлагатай тохиолдолд олон нийтийн газарт (гаалийн хяналт шалгалт хийгээгүй үед) тоног хэрэгслийг хэрэглэн, зөөврийн үүрэнд хийж, эрэлч нохойг авч явна.

4.1.9 Жолооч нь ажил үүргээ гүйцэтгэхдээ:

- Тээврийн хэрэгслийн жолооч нар нь замын хөдөлгөөнд оролцох болон автомашинд засвар үйлчилгээ хийх үедээ “Монгол Улсын замын хөдөлгөөний дүрэм”-ийг дагаж мөрдөх, гарч болох аюул, ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор энэхүү ХАБЭАЗ-г дагаж мөрдөнө.

- Жолооч нар нь ажилд гарахын өмнө болон албан томилолтоор явахдаа холбогдох албан тушаалтнаас ХАБЭАЗ-г авч, танилцсан талаар гарын үсэг зурж, баталгаажуулсан байна.
- Жолооч нь тээврийн хэрэгслийн аюулгүй, бүрэн бүтэн байдлыг хариуцаж, хөдөлгөөнд оролцохдоо тээврийн хэрэгсэлд урсгал болон их засвар хийх тохиолдолд дараах зааврыг дагаж мөрдөн ажиллах шаардлагатай.
- Хувийн болон техникийн бүрэн бүтэн байдлыг хангасан байна.
- Зөвшөөрөлгүйгээр дур мэдэн хувийн зорилгоор албаны тээврийн хэрэгслийг ашиглахгүй байх, ашигласан тохиолдолд гарсан үр дагавар, хариуцлагыг жолооч өөрөө хариуцах бөгөөд албан байгууллага ямар нэгэн хариуцлага хүлээхгүй.
- Согтуугаар болон тээврийн хэрэгсэл жолоодох чадамжгүй үед автомашин жолоодохыг хатуу хориглоно.
- Жолоо шилжүүлэх, тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй хүнээр жолоо бариулахыг хориглоно. Жолоо шилжүүлснээс үүсэх үр дагавар, хариуцлагыг тухайн тээврийн хэрэгслийн жолооч хариуцна.
- Замын хөдөлгөөнд оролцохдоо гар утас болон бусад анхаарал сарниулах зүйлсийг ашиглахгүй байна.
- Тээврийн хэрэгслийн хурдыг тогтоосон хэмжээнээс хэтрүүлэх, шалтгаангүйгээр хэт удаан явах, огцом зогсох, хөдөлгөөн саатуулах, тээврийн хэрэгсэлд дуут дохио болон гэрлэн дохио дур мэдэн тавихыг хориглоно.
- Тээврийн хэрэгслийн суудлын тоогоор зорчигчдыг суулгах, хүн хэтрүүлж суулгахгүй байна.
- Зорчигчийг тээврийн хэрэгсэлд бууж, суух үед зөвшөөрөгдсөн зогсоолд зогсож, гүйцэд бууж, суусны дараа хөдлөнө.
- Шатахуун түгээх газар болон шатах, тослох материалын ойр орчимд ил гал гаргах, тамхи татахыг бүрэн хориглоно.
- Өвөл, зуны улиралд зориулалтын дугуйг ашиглах ба хол замд гарахаар бол хүрз, тросс, паяльник зэрэг зайлшгүй шаардлагатай зүйлсийг авч явна.
- Ажлын байранд болон тээврийн хэрэгсэлд гал унтраах багаж хэрэгслийг байнга байлгаж, зориулалтын бус зүйлд ашиглахгүй байна.
- Шаардлагатай тохиолдолд хэрэглэх дараах эд зүйлсийг бэлэн байлгах. Үүнд:
 - Галын хор, ослын гурвалжин болон засвар хийхэд шаардлагатай багаж, хэрэгсэл
 - Ажлын бээлий, нүдний шил, амны хаалт, нойтон салфетка, эмийн сан гэх мэт.
- Автомашины цэвэрлэгээ, үйлчилгээг тогтмол хийж, шороо, тоос, ус, цас, мөс, тосыг байнга арчиж цэвэрлэх, эд зүйлсийг цэвэр, эмх цэгцтэй байлгана.
- Ус, тос, маслыг байнга шалгах, нэмэх, шинээр сольж байх шаардлагатай.
- Автомашины эрэг, боолтуудыг тогтоосон хугацаанд шалгаж, чангалж байна.
- Автомашиныг жил бүр оношилгоонд оруулж, түүний дагуу шаардлагатай засвар үйлчилгээг хийж байна.
- Засвар, үйлчилгээг хийхдээ автомашины мотор хөдөлгүүрийг бүрэн зогсоож, унтраасны дараа засварын ажлыг эхлүүлнэ.

- Засварын ажлын явцад өргөж, буулгах механизмуудын даацыг хэтрүүлэхгүй байна.
- Зөөврийн цахилгаан гэрэл ашиглахдаа 6 вольтоос илүү хүчдэлтэйг хэрэглэхгүй байх, чийгтэй нойтон орчинд 12 вольтоос илүү хүчдэлтэйг үл хэрэглэнэ.
- Цахилгаан багажаар ажиллах үед хамгаалалтын бээлийг заавал өмсөж, төмөр дээр зогсож, цахилгаан багажаар ажиллах бол хамгаалалтын резинэн дэвсгэр хэрэглэнэ.

4.1.10 Үйлчлэгч нь ажил үүргээ гүйцэтгэхдээ:

- Угаалгын нунтаг, ариутгалын бодис найруулах, цэвэрлэгээ хийх, хог хаягдлыг хаяхдаа эрүүл ахуй, халдвар, хамгааллын дэглэмийг дагаж мөрдөнө. Халуун усанд түлэгдэх, хүйтэнд хөлдөж, хайрагдахаас урьдчилан сэргийлнэ.
- Ажилд гарахын өмнө ажлын багаж хэрэгслийн / хувин, шүүр, хутгуур, алчуур, тоос сорогч гэх мэт/ бүрэн бүтэн байдлыг шалгана.
- Шал, хонгил, ариун цэврийн өрөөг угааж цэвэрлэхдээ 1%-ийн хлорын шохойн уусмал хэрэглэнэ. Уусмалыг бэлтгэхдээ анхаарал болгоомжтой байж, амны хаалт, нүдний шил зүүнэ.
- Ажил үүргээ гүйцэтгэхдээ ажлын бээлий, амны хаалт, ажлын хувцсыг тогтмол хэрэглэх, ажлын хувцас нь тухайн ажлыг хийхэд саад учруулахааргүй байна.
- Цэвэрлэгээ хийхдээ бусдад саад болохгүй байдлаар ажиллана.
- Ариун цэврийн өрөөг бохирдсон тухай бүрд нь болон өдөрт хоёроос доошгүй удаа халдваргүйжүүлэгч бодис ашиглаж цэвэрлэх ба 7 хоног тутамд ариутгал хийсэн байна.
- Техник, тоног төхөөрөмж, цахилгаан хүчдэлийн ойр орчмыг цэвэрлэх, тоос шороог арчихдаа анхаарал болгоомжтой байна. Мөн цахилгаан хүчдэл, тогонд цохиулах, гэмтэж бэртэх, халтирахаас болгоомжлоно.
- Хүйтний улиралд зам талбай, орц хонгилыг цэвэрлэхдээ даарч хөрөх, халтирахаас болгоомжлох, зам талбайд халтиргаа гулгаа үүсэхээс сэргийлэн элс, давс, шороо цацан, наалт наана.
- Цасан болон шороон шуурга, хүчтэй аадар, мөндөр зэрэг байгалийн онц аюултай үзэгдлийн үед гадна зам, талбайн цэвэрлэгээ хийхгүй байна.
- Байгууллагын цонх, хаалга, хана, шүүгээ зэрэг өндөрт байрлах зүйлсийг угааж арчихдаа анхаарал болгоомжтой байж, стандартын шаардлага хангасан зориулалтын шат, урт бариул бүхий цэвэрлэгээний сойз, алчуурыг ашиглан цэвэрлэнэ.
- Хог хаягдлыг уут саванд хийж, зориулалтын цэгт хаяна.

4.1.11 Гагнуурчин нь ажил үүргээ гүйцэтгэхдээ:

- Гагнуур хийх ажлын шаардлага гарсан тохиолдолд цахилгааны инженер нь гагнуурчинд цахилгаан гагнуур хийх талаар танилцуулж, ажлын дэс дарааллыг зааж зөвлөх үүрэг хүлээнэ. Цахилгаан гагнуур хийх явцад хяналт тавьж, удирдлагаар ханган мэргэжлийн туслалцаа үзүүлнэ. Гагнуурчинд хөдөлмөрийн аюулгүй байдал, аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгааг танилцуулж, гарын үсэг зуруулна.
- Цахилгаан гагнуурчин нь нарийн мэргэжлийн эмнэлгийн үзлэгт орж магадлагаа гаргуулсан, гагнуурчны мэргэжлийн үнэмлэх авсан, насанд хүрсэн эрэгтэй хүн

байх ба хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн заавартай танилцаж, гарын үсэг зурсны дараа ажилд гарна. Цахилгаан гагнуурчин нь гагнуур хийх явцад дараах зааврыг дагаж мөрдөн ажиллана. Үүнд:

- Цахилгаан гагнуур хийж эхлэхээс өмнө ажил эхлэх бэлтгэлийг хангаж, хөдөлмөр хамгааллын хувцсыг өмсөж, зориулалтын нүдний шил, нүүрний хамгаалалт баг, малгай, бээлий зэргийн бүрэн бүтэн байдлыг шалгаж, зохих зааврын дагуу өмсөж, хэрэглэнэ.
- Цахилгаан гагнуурын хурц туяанаас орчинд учирч болох аюулаас хамгаалж, сэргийлэн зөөврийн хамгаалалтын самбараар ажлын байрыг тойруулан хамгаалалт хийсэн байна.
- Орчны гэрэлтүүлэг нь гагнуурчны нүдэнд шууд тусч гялбуулахгүй байхад анхааран, байгалийн болон зохиомол цахилгаан гэрэлтүүлэг нь гагнуур хийхэд хүрэлцэхүйц гэрэлтүүлж байх нөхцөлийг бүрдүүлсэн байна.
- Гагнуурын аппаратыг цахилгаан тогонд холбосон цахилгааны самбараас 100 метрээс ойр биш зайд байрлуулсан байх ба цахилгаан гүйдэл дамжуулж байгаа утасны бүрхүүл шалбарч гэмтсэн эсэхэд шалгалт хийн, гэмтсэн тохиолдолд тогонд залгахаас өмнө хамгаалах арга хэмжээг авсан байна.
- Гагнуурын ажил эхлэхээс өмнө орчны хүмүүст анхааруулан, шаардлагагүй хүмүүсийг ажлын байранд байлгахыг хориглоно.
- Гагнуурын хортой хийг зайлуулахын тулд агааржуулалтыг ажиллуулж, салхивчийг нээлттэй байлгана.
- Нойтон чийгтэй, халтиргаатай газар зохих хамгаалалтгүйгээр ажиллахгүй байна.
- Гагнуурын аппаратыг тогонд залгах, салгах, мөн засварлах ажлыг зөвхөн мэргэжлийн хүмүүсээр гүйцэтгүүлнэ.
- Гагнуурын аппаратын ажиллагаа хэвийн байгаа эсэхийг шалгаж, гэмтэл илэрсэн тохиолдолд инженер, техникчдэд мэдэгдэж засуулан аюулгүй болсны дараа ажлыг эхлүүлнэ.
- Гагнуурын аппаратын их биеийг газардуулаагүй, гагнуурын аппарат техникийн паспортонд заагдсан хэвийн ажиллах шаардлагыг хангахгүй байгаа тохиолдолд ажиллахаас татгалзан, ажиллах техникийн нөхцлийг бүрдүүлэхийг шаардана.
- Цахилгаан гагнуурыг үргэлжлүүлэн удаан хугацаагаар хийх тохиолдолд электрод солих, түр амрах, үдийн хоол идэхээр явах зэрэг үед цахилгааныг автоматаар салгуулна.
- Гагнуурын ажлыг тогтоосон ажлын байрнаас өөр газарт хийх шаардлага гарсан тохиолдолд зөвхөн удирдлагын зөвшөөрлөөр хийж гүйцэтгэнэ.
- Цахилгаанчин нь гагнуурчинд цахилгаан гагнуур хийх явцад мэргэжлийн туслалцаа үзүүлэхдээ цахилгаан тоног төхөөрөмжтэй ажиллах үед хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааврыг дагаж мөрдөх бөгөөд хөдөлмөр хамгааллын хувцас, бээлийг өмсөж, зориулалтын хамгаалах багаж хэрэгслийг ашиглан уг ажлыг хийхэд туслалцаа үзүүлнэ.
- Цахилгаан гагнуурын ажил эхлэхээс өмнө цахилгаанчин гагнуурчинтай хамтран гагнуурын аппаратны цахилгаан утсыг шалгаж, гэмтлийг засна.
- Цахилгаан аппаратыг газардуулсан байна.

- Гагнуурчныг ажил гүйцэтгэх үед цахилгаанчин дэргэд нь байж шаардлагатай үед мэргэжлийн туслалцаа үзүүлэн цахилгааныг автоматаар залгаж, салгаж өгнө.

4.1.12 Мужаан нь ажил үүргээ гүйцэтгэхдээ:

- Байгууллагаас олгосон хөдөлмөр, хамгааллын хувцас, малгай, бээлий, нүдний шил, амны хаалтыг тогтмол өмсөж, ажилд шаардагдах хөдөлмөрийн багаж хэрэгслийн бүрэн бүтэн, аваар осолгүй байдлыг хангаж, ажиллана.
- Байгууллагын барилга байгууламж, тавилга, эд хогшлийн бүрэн бүтэн байдалд хяналт тавьж, тогтмол үзлэг шалгалт хийж, урсгал засвар, эвдрэл, гэмтлийг засна.
- Галын аюулгүй байдлыг ханган, хяналт тавина.
- Цахилгаан хангамжийн их болон урсгал засварын ажлыг хариуцан гүйцэтгэж, зохион байгуулна.
- Байгууллагын цахилгааны шугам, сүлжээ, узель болон бусад тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг байнга шалгаж засвар үйлчилгээ, баталгаажуулах ажлыг хийж гүйцэтгэнэ.
- Цахилгаанчны засварын өрөөг тохижуулан, багаж хэрэгслээр хангана.
- Өрөөнүүдийн цахилгааны доголдыг дуудлагыг дагуу шуурхай засаж, хэвийн ажиллагаатай болгох ажлыг хийнэ.
- Байгууллагын барилга объектийн цахилгааны холболт болон гэрэлтүүлгийн төхөөрөмж, ахуйн хэрэглээний цахилгаан хангамжийн хэвийн найдвартай ажиллагааг хангах ажлыг мэргэжлийн түвшинд гүйцэтгэнэ.
- Гар хөрөөгөөр материалыг зүсэхдээ хавчлаганд хөдөлгөөнгүй сайн бэхэлж, хөрөө сугарахаас болгоомжлоно.
- Төмөр эдлэлийг хуурайдахдаа хавчлаганд хөдөлгөөнгүй сайн зуулгаж байж хуурайдана.
- Алх, муна зэрэг багаж хэрэгслийг хөдөлгөөнгүй, сугарахгүйгээр сайн ишлэсэн байна.
- Цахилгаан хөрөө, дрилл, точил зэрэг цахилгаанаар ажилладаг багажтай анхаарал болгоомжтой ажиллана.

4.1.13 Галч нь ажил үүргээ гүйцэтгэхдээ:

- Сантехникийн инженер нь өдөр бүр уурын зуухны ажилтай танилцаж, галч нарын ээлжийг хүлээлцүүлж ажилд гарч байгаа ээлжийн галч нарт ажил үүргийн талаар нэмэлт, заавар зөвлөгөө, үүрэг даалгавар өгч, удирдлагаар ханган зааварчилгааг танилцуулан гарын үсэг зуруулж ажиллана.
- Галч нар нь эмнэлэгийн үзлэгт орж магадлагаа гаргуулсан, насанд хүрсэн эрэгтэй хүн байна. Ээлжийн галч нар нь уурын зуухыг галлахдаа сантехникийн инженер болон ээлжийн слесариас өгсөн хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн зааварчилгаа авсан тухай гарын үсэг зурсны дараа ажилд гарна.
- Галч нар нь зуухыг галлахдаа дараах зааврыг дагаж мөрдөн ажиллана. Үүнд:
- Ажлын бэлтгэл хангаж, хөдөлмөр хамгааллын нормын хувцсыг өмсөн, нүдний шил, хошуувч, бээлийг хэрэглэн, ажлын багаж, хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хангана.

- Ээлж хүлээлцэхдээ байгууллагын эд хогшил, галын аюулгүй байдал, гарч болзошгүй эрсдэлийн талаар удирдлагад мэдээлж байна. Удирдлагын зөвшөөрөлгүй ээлжийн графикыг зөрчиж ажиллахыг хориглоно. Зуухыг галлахдаа хариуцсан ээлжийн слесарийн зөвшөөрлөөр галлана.
- Галч нь хянах, хэмжих хэрэгсэл монометр, термометр зэргийг байнга хянан, хэмжилтийн горимд доголдол гарсан тохиолдолд цаг алдалгүй ээлжийн слесарьд мэдэгдэн, шалтгааныг тодруулан шаардлагатай арга хэмжээг авна.
- Зуухыг ажиллаж байгаа үед хяналтгүй орхиж явахгүй байна. Зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд вентиляторыг унтрааж орхино.
- Зуухны галын хөтөлд нүүрс болон түлээг хийж, амыг нь хааж, зориулалтын түгжээгээр түгжиж байна.
- Зууханд шатаж байгаа нүүрсийг шилгээх, бутлах үед заавал хамгаалалтын нүдний шилтэй байна.
- Цахилгаан эрчим хүч тасарсан тохиолдолд бүх цахилгаан хөдөлгүүрүүдийг яаралтай салган, галыг манаж, ээлжийн слесарь, инженерт яаралтай мэдэгдэнэ.
- Цахилгаан хүчдэл хэлбэлзэж, 380 вольтоос доошоо унасан үед цахилгааны автоматыг яаралтай салгаж, зуухны цог, нурмыг зөөвөрлөх арга хэмжээ авна.
- Усны даралтыг шаардлагатай түвшинд барьснаар ус халаагуурын зуух хэвийн горимоор ажиллана.
- Зуухыг дараах нөхцөлд галлахгүй:
 - Тэжээлийн усны бүх төхөөрөмж ажиллахгүй,
 - Аваарын хавхлага ажиллаагүй,
 - Зуухан дотор гэмтэл гарч, ус алдсан,
 - Усны температур өсч, чимээ гарсан,
- Тогооны утааны сувагт цэвэрлэгээ хийхэд 2-оос доошгүй галч цэвэрлэгээг хийнэ.
- Зуух галлаж байх үед ажлын байрны хаалгыг түгжихгүй, хаалганы орчмын цас мөсийг тогтмол цэвэрлэн, байнга гэрэлтүүлэгтэй байлгана.
- Угаар гарсан үед хаалга, цонхоо нээн өөрийгөө хордохоос хамгаална.
- Инженер, слесарийн удирдлага дор цэвэрлэгээ үйлчилгээ, урсгал болон цаг үеийн гэнэтийн шаардлагатай засвар угсралтын ажлыг хийж, зуухыг галлаагүй үед эсвэл хөдөлгүүр бүрэн зогсож, зуух хөрсний дараа цэвэрлэгээг хийнэ.
- Ажлын байранд тавигдсан галын хор, гал унтраах багаж хэрэгслийг зориулалтын бус ажилд хэрэглэхийг хориглоно.
- Галлагааны өрөөнд будаг, бензин гэх мэт галд тэсвэргүй, амархан шатах, тэсрэх бодис, эд зүйлсийг хадгалахыг хатуу хориглоно.
- Ажлын байранд гадны хүн оруулахыг хориглоно.
- Зуухны вентиляторыг унтраахгүй үнслэх, ажиллагаа хийхийг хориглоно.
- Зуухыг галласан үед болон хөдөлгүүрүүд ажиллаж байх үед зуухыг хараа хяналтгүй орхиж явахыг хориглоно.

4.1.14 Худгийн моторчин, сахиул-худгийн ажилтан нь ажил үүргээ гүйцэтгэхдээ:

- Цахилгааны инженер нь 7 хоногт нэг удаа гүний өрөмдмөл худгийн ажил байдалтай танилцан, шаардлагатай мэргэжлийн туслалцаа, засвар үйлчилгээг хийлгэн өгч, хариуцсан ажилтанд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгаа өгч, гарын үсэг зуруулж ажиллана.
- Гүний өрөмдмөл худгийг хариуцан ажиллуулагч нь худаг ажиллуулах мэргэжлийн буюу мэргэшсэн хүн байх ёстой бөгөөд жилд 2-оос доошгүй удаа эрүүл мэндийн үзлэгт орж шинжилгээ өгч, эрүүл мэндийн дэвтэртээ тэмдэглэл хийлгэсэн байх шаардлагатай ба эрүүл мэндийн дэвтрээ биедээ байнга авч явах үүрэгтэй.
- Худгийн ус өргөх цахилгаан насосыг ажиллуулж, ус шахахдаа ажлын бэлтгэлийг ханган хөдөлмөр хамгааллын хувцсыг өмсөж, зориулалтын багаж, хэрэгслийг бэлтгэсэн байна.
- Усыг өргөх насосыг ажиллуулахын өмнө цахилгааны хүчдэл хэвийн байгаа эсэх, фазууд бүрэн ажиллаж байгааг заавал хянаж шалгана.
- Насосны хэвийн ажиллагааг хангах үүднээс удирдах самбар дээрх хяналт, хэмжилтийн багажуудын заалтад тогтмол хяналт тавьж ажиллана.
- Насосыг автомат удирдлагын самбараар дамжуулан ажиллуулна.
- Насос ажиллаж байх үед хүчтэй доргилт, чичиргээ үүсэх, ямар нэг хэвийн биш чимээ шуугиан гарвал насосыг даруй зогсоож, энэ тухай инженерт болон холбогдох мэргэжлийн хүнд мэдэгдэн, шалтгааныг тодруулан, засвар үйлчилгээг хийлгэнэ.
- Насос ажиллаж байгаа үед амперметрийн заалтанд байнга хяналт тавьж, заалт хэвийн биш болсон тохиолдолд насосыг унтраана.
- Насосны удирдах самбарын хаалгыг үргэлж хаалттай байлгах ба ус орохоос хамгаалан цоожтой байлгана.
- Ажиллаж байх үед нь цахилгаан гүйдлийн хэмжээ ихэсвэл гүний худгийн толгой хэсэг дэх хаалтыг хааж, гүйдлийг хэвийн хэмжээнд болгоно. Харин хаалтыг хаахад гүйдлийн хэмжээ хэвийн байдалдаа эргэн очихгүй байвал насосыг ажиллуулахыг зогсооно.
- Удирдлагын самбарын бүх хэсгүүдийг сард нэгээс доошгүй удаа цахилгаанчинд үзүүлж, цэвэрлэгээ хийлгэн, эрэг боолт, бэхэлгээг шалгаж, чангалуулна. Цэвэрлэгээ, үйлчилгээг хийхдээ хүчдэлийг салгасны дараа ажлыг эхлэнэ.
- Гүнээс гарч байгаа усны гарц, чанарт хяналт тавьж, усанд элс шороо үзэгдвэл насосыг ажиллуулахыг зогсоон, шалтгааныг тодруулна.
- Аливаа засвар, үйлчилгээ, эвдрэл, гэмтлийг мэргэжлийн хүнээр хийлгэх бөгөөд дур мэдэн оролдсоноос учирсан хариуцлага, хохирлыг худаг ажиллуулагч өөрөө хариуцана.
- Хүйтний улиралд худгийг галлах үед гал алдахаас урьдчилан сэргийлж, галын аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор шаардлагатай галын хор болон багаж, хэрэгслийг байнга бэлэн байлгана.
- Сард нэгээс доошгүй удаа гүний худгийн насос түүний удирдах самбарын хэвийн ажиллагаа, цахилгаан гүйдэл, хүчдэлийн хэлбэлзлийн хэвийн байдалд үзлэг шалгалт хийнэ.

- Цахилгааны тэжээлийн кабель утас, холболтын контактуудад халалт үүсч байгаа эсэх, бүрээс нь халсан, шалбарсан эсэхэд үзлэг хийж, шаардлагатай солих хүртэлх арга хэмжээг авна.
- Насосыг удирдах самбараар дамжуулалгүй шууд хүчдэлтэй шугаманд холбож ажиллуулахыг хориглоно.
- Удирдах самбарт гэмтэл гарч автомат залгуур залгагдахгүй байгаа нөхцөлд хүчээр гацааж, залгаж ажиллуулахыг хориглоно.
- Насосыг нэг дор дахин дахин салгаж, залгахгүй байна.
- Шугамын хүчдэл хэвийн хэмжээнээс хэлбэлзэх тохиолдолд насосыг ажиллуулахыг зогсооно.
- Худгийн насосны цэвэрлэгээ, үйлчилгээ, засварыг худаг ажиллуулагч өөрөө хийхийг хориглоно.

4.1.15 Сахиул, манаач нь ажил үүргээ гүйцэтгэхдээ:

- Байгууллагын гадна, дотор талын (барилга, хашаа, байшин, гараж, эд хөрөнгө) бүрэн бүтэн байдлыг ээлжийн ажлын хугацаанд бүрэн хариуцаж, аюулгүй байдлыг ханган ажиллана.
- Манаачийн өрөөнд будаг, бензин, солярка зэрэг химийн хорт бодис хадгалахыг хориглоно.
- Өрөөг дулаацуулах зорилгоор ил задгай тень, плитка залгах, залгаатай орхиж гарах, плитка залгаж тамхи асаах зэргийг хориглоно.
- Гэрэлтүүлэг чийдэн шатсан ба гэмтсэн үед даруй удирдлагад мэдэгдэнэ.
- Автомашинуудыг эмх замбараатай, гарцыг чөлөөтэй байхаар зогсоолд тавиулна.
- Цахилгаан залгуур, рубильникийг дур мэдэн залгах, салгахыг хатуу хориглоно.
- Удирдлагын зөвшөөрөлгүй байгууллагын хашаа, гараж, паркад гадны машин тавиулахыг хориглоно.
- Манаач, сахиулын өрөөнд гадны хүн оруулах, байлгахыг хориглоно.
- Ээлжийн хугацаандаа ажил тарсны дараа бүх өрөө, тасалгааны гэрэлтүүлэг, цоож, цонх, хаалгануудын байдалд хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээг цаг алдалгүй шуурхай авна.
- Ээлжийн хугацаанд байгууллагын орчин тойрон, зам талбай, довжоо, хашааны дотор, гадна байрлалд зохих цэвэрлэгээг хийж, хүлээлцэж хэвшинэ.
- Хариуцсан объектоо тодорхой хугацаагаар эргэн тойрч, гарч болзошгүй гал, усны болон гэнэтийн аюул, хулгай дээрмээс сэргийлэх зорилгоор үзлэг, шалгалтыг тогтмол хийж, илэрсэн зөрчлийн талаарх шуурхай мэдээллийг удирдлагуудад болон зохих албан байгууллага (цагдаа, гал команд гэх мэт)-д зохих журмын дагуу мэдэгдэнэ.
- Байгууллагын хэмжээнд байгаа объектуудын цоож, лац ломбыг нарийн шалгаж, илэрсэн зөрчлийг тухайн ажилтнаар арилгуулж хүлээн авсан тухай тэмдэглэл хөтлөн гарын үсгээр баталгаажуулна.
- Автомашин гараж, өрөө тасалгааг гал, усны аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор шаардлагатай үед онгойлгон үзэж магадлах, цаг алдахгүй арга хэмжээ авах үүрэгтэй.
- Ажилтан, албан хаагчид болон иргэдээс биеийн байцаалт (ажлын газрын үнэмлэх, иргэний үнэмлэх)-ыг нь шаардах ба онцын шаардлагагүй болон

согтууруулах ундаа хэрэглэсэн хүнийг албан байгууллагад нэвтрүүлэхийг хориглоно.

- Ажлын байранд архи, согтууруулах ундаа хэрэглэж буй тохиолдол илэрсэн үед удирдлагад шуурхай мэдэгдэнэ. Сэжиг бүхий иргэдийн талаар цагдаагийн байгууллагад яаралтай мэдэгдэх, онцгой шаардлагатай албан тушаалтан, ажилтнуудын утасны жагсаалтыг бэлэн байдалд байлгаж, хэрэглэж хэвшинэ.
- Ээлж хүлээлцэхдээ байгууллагын эд хогшил, бүрэн бүтэн байдалд биечлэн шалгалт хийж байхын зэрэгцээ ээлжийг зохих графикайн дагуу ажил эхлэхээс 15 минутын өмнө хүлээлцсэн байна.
- Удирдлагад мэдэгдэлгүйгээр ээлжийн графикайг зөрчин ажиллахыг хориглоно.
- Шалбарсан цахилгааны утас, залгуурыг 220 вольтын хүчдэлд залгахыг хориглоно.

---oOo---

ЗААВАРЧИЛГАА №5

НЭГ. АЛБАН ТОМИЛОЛТООР ЯВАХ АЛБАН ХААГЧДЫН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА

5.1 ГЕГ, харьяа гаалийн газар, хороодод болон хөдөө, орон нутагт албан ажлаар томилолтоор явах албан хаагчид болон жолооч нь замд гарахын өмнө “Албан томилолтоор явах албан хаагчдын аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-тай танилцаж, танилцсан болохоо гарын үсгээр баталгаажуулна. Зааварчилгааг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллана.

АЛБАН ТОМИЛОЛТООР ЯВАХ АЛБАН ХААГЧДЫН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА

Монгол Улсын “Хөдөлмөрийн тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэг, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай” хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.1, 18.2.2, 18.2.3, 18.2.6, 18.2.7, 18.2.8 дахь заалт, “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль”, Засгийн газрын 2018 оны 239 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын замын хөдөлгөөний дүрэм”, Гаалийн ерөнхий газрын даргын 2016 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн “Журам батлах тухай” А/93 тушаалаар батлагдсан “Гаалийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журам”-ын 4.2.9 дэх заалтыг үндэслэн дараах зааварчилгааг өгч байна.

№	ТОМИЛОЛТООР ЯВАХ АЛБАН ХААГЧИД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА	ЖОЛООЧИД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА
1	Ажилтан томилолтоор явахдаа өөрт шаардагдах эм, тариа, цаг агаар, улирлын байдалд тохирсон хувцас болон шаардлагатай бусад зүйлээ бэлтгэх,	Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмийг сахин биелүүлэх,
2	Бүрэн бүтэн, эвдрэл, гэмтэлгүй, зөвшөөрөлтэй тээврийн хэрэгслээр зорчих,	Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж чадахааргүй өвчтэй буюу ядарсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодож замын хөдөлгөөнд оролцохгүй байх,
3	Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ автомашин жолоодохгүй, жолоочид шаардлага тавихгүй байх,	Зам дээр болон түүний ойр орчимд ажил, үйлчилгээ хийхдээ замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах,
4	Хамгаалалтын бүсийг урд суудал, арын суудалд суусан зорчигчид бүгд хэрэглэж хэвших,	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, зөрчлийн талаар холбогдох байгууллагад шуурхай мэдээлэх,
5	Гэмт халдлагад өртвөл цагдаа, хууль сахиулах байгууллага, эмнэлэг болон удирдлагад яаралтай мэдэгдэх,	Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах талаар эрх бүхий этгээдээс тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэх,

6	Томилолтоор очих газар руу явахдаа аюулгүй замыг сонгох,	<p>Эвдрэл, гэмтэл, техникийн зөрчилгүй байхаар тээврийн хэрэгслийнхээ бүрэн бүтэн байдлыг хангах:</p> <ul style="list-style-type: none"> • Тээврийн хэрэгслийн ажлын тоормосны систем, жолооны механизм ажиллахгүй болсон, чиргүүлийн холбоос (чиргүүлтэй үед) эвдэрсэн, харанхуй үед болон үзэгдэх орчин хангалтгүй нөхцөлд хол, ойрын буюу ар талын оврын гэрэл асахгүй болсон, цас, бороо орж байгаа үед жолооч талын шил арчуур ажиллахгүй бол хөдөлгөөнөө үргэлжлүүлэхийг хориглоно. • Хөдөлгөөнд оролцож явах үед тээврийн хэрэгсэлд дээр дурдсанаас бусад гэмтэл тохиолдвол түүнийг засах, хэрэв бололцоогүй бол аюулгүй байдлыг хангаж аль ойр байгаа зогсоол (гараж) буюу засварын газарт очих хүртэл хөдөлгөөнөө үргэлжлүүлэхийг зөвшөөрнө.
7	Газрын зураг болон GPS-тэй явах,	Хамгаалах бүсээр тоногдсон автомашин жолоодохдоо хамгаалах бүс хэрэглэх, хамгаалах бүсийг хэрэглээгүй зорчигч тээвэрлэхгүй байх,
8	Өдрийн цагаар буюу нартай байгаа үед замд явах,	Хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд ноцтой хохирол учирсан байж болзошгүй зам тээврийн ослын тохиолдол харсан даруйд очиж бололцоотой тусламж үзүүлэх, цагдаа, эмнэлгийн байгууллагад яаралтай мэдэгдэх, зам тээврийн осолд өртсөн хүнд эмнэлгийн анхны тусламж үзүүлэх, эмнэлэгт яаралтай хүргэх,
9	Шуурга, цас, аадар бороо, газар хөдлөлт, түймэр зэрэг байгалийн гамшигт үзэгдэл тохиолдсон үед ойр харагдсан айл, суурин газрыг олж хорогдох, мэдээлэл авах, удирдлагад мэдээлэл өгөх,	Зам тээврийн осол, байгалийн гамшиг болон бусад аюул, эрсдэлд өртөж болзошгүй нь илэрхий байдалтай саатаж зогссон (зайлшгүй зогсолт хийсэн) жолоочийн дохиогоор зогсож, бололцоотой тусламж үзүүлэх,
10	Ажлын томилолт, удирдамжид тусгаснаас бусад ажил гүйцэтгэх болон өөр газар, чиглэлд явахгүй байх,	Согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн эсэх буюу тээврийн хэрэгсэл жолоодоход эрүүл мэндийн хувьд тэнцэж байгаа эсэхийг, мөн шаардлагатай тохиолдолд тээврийн хэрэгсэл жолоодох ур чадвараа цагдаагийн эрх бүхий ажилтны шаардлагаар зохих журмын дагуу шалгуулах,

11	Холбоо барих утсаа байнга цэнэгтэй, нээлттэй байлгах,	Зам дээр ажил, үүрэг гүйцэтгэж байгаа хүн, явж байгаа мал, амьтны дэргэдүүр өнгөрөхдөө хурдаа хасаж, түүнд аюул, осолтой байдал үүсгэхгүйгээр зорчих,
12	Албан томилолтоор замд гарахын өмнө “Аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-тай заавал танилцсан байх.	Албан томилолтоор замд гарахын өмнө “Аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-тай заавал танилцсан байх.

..... оны сарын өдрүүдэд газарт албан томилолтоор /томилолт №/ явсан албан хаагчдын аюулгүй ажиллагааны зааварчилгаатай танилцсан байдал:

Тээврийн хэрэгслийн төрөл: /доогуур зурна/

- Галт тэрэг,
- Автомашин,
- Нисэх онгоц,
- Усан онгоц

АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГААТАЙ ТАНИЛЦСАН:

Ажлын хэсгийн ахлагч / /
 (нэгж, албан тушаал) (нэр) (гарын үсэг)

Ажлын хэсгийн гишүүд: / /
 (нэгж, албан тушаал) (нэр) (гарын үсэг)

.....-ны жолооч / /
 (нэгж) (нэр) (гарын үсэг)

Зааварчилгааг танилцуулсан : / /
 (нэр) (гарын үсэг)

---oOo---